



**“Байгалийн баялаг- Сайн засаглал-Хөгжсөн
Өмнөгөв” аймгийн хөгжлийн хөтөлбөр
(2010-2020 он)**

ТАЛАРХАЛ

Судалгааны багийн зүгээс Өмнөговь аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийг боловсруулах ажлын орон нутгийн судалгаа, гурван удаагийн хэлэлцүүлэгт оролцсон бүх хүмүүст талархаж буйгаа илэрхийлэе.

Онцгойлон Өмнөговь аймгийн засаг дарга Б.Бадраа, Засаг даргын орлогч Д.Мөнхтулга, Хөгжлийн бодлогын хэлтэсийн дарга Б.Энхтуяа, мэргэжилтэн Н.Чинжаргал, Б.Отгонбаяр, Ж.Сүх-Эрдэнэ нарт.

Мөн түүнчлэн МУИС-ын Эрдэм шинжилгээ эрхлэсэн дэд захирал проф Р.Самъяа, Үндэсний Хөгжил Шинэтгэлийн хорооны мэргэжилтэн С.Оюунцэцэг нарт талархаж буйгаа илэрхийлэе.

Хөгжлийн хөтөлбөрийг Өмнөговь Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын зөвшөөрөлтэйгөөр, ашгийн бус зорилгоор олшруулж, тарааж болно.

Өмнөговь аймгийн хөгжлийн бүсчилсэн хөтөлбөрийн эх материалуудыг бэлтгэсэн эх бичигчид

М.Чимэддорж, Судалгааны багийн ахлагч, Төгс Шийдэл ХХК, Судалгааны албаны дарга

С.Буяндэлгэр, Судалгааны багийн гишүүн, Төгс Шийдэл ХХК, Стратегийн шинжээч

Б.Дөлгөөн, Судалгааны багийн гишүүн, Төгс Шийдэл ХХК, Санхүүгийн шинжээч

О.Эрдэнэ-Өрнөх, Судалгааны багийн гишүүн, Төгс Шийдэл ХХК, Гүйцэтгэх захирал

О.Баяндүү, Судалгааны багийн гишүүн, Төгс Шийдэл ХХК, Дагалдан судлаач

Э.Мөнхсоёл, Судалгааны багийн гишүүн, Төгс Шийдэл ХХК, Санхүүч

Зөвлөхүүд

Др. Л.Цэдэндамба, Үндэсний Хөгжлийн Хүрээлэн, Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Б.Лхагва, Бүсчилсэн Хөгжлийн Үндэсний Хороо, Ажлын албаны дарга

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт.....	6
Өмнөтгөл.....	7
Бүлэг I.Хөтөлбөрийн Концепц.....	8
1.1.Нийгмийн салбарын хөгжлийн үзэл баримтлал.....	10
1.2.Эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал.....	10
1.3.Байгаль орчны тогтвортой байдлын үзэл баримтлал.....	11
1.4.Хотын хөгжлийн үзэл баримтлал.....	12
Бүлэг II.Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийн Үндэслэл.....	13
2.1.Нийгмийн хөгжлийн бодлогын үндэслэл.....	14
2.2.Байгаль орчны тогтвортой байдлын бодлогын үндэслэл.....	16
2.3.Хот байгуулалтын бодлогын үндэслэл.....	18
Бүлэг III.Хүн Ам Зүй, Нийгмийн Салбарын Хөгжлийн Бодлого.....	22
3.1.Хүн амын өсөлтийг түргэтгэх, хүний хөгжлийг хангахад чиглэсэн стратегийн зорилтууд.....	22
3.2.Хэрэглээний бүтцийг сайжруулах стратегийн зорилтууд.....	23
3.3.Ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах стратегийн зорилтууд.....	24
3.4.Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх стратегийн зорилтууд.....	25
3.5.Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн стратегийн зорилтууд.....	27
3.6.Хүн амын нутагшилт, соёлын өв хадгалахад чиглэсэн стратегийн зорилтууд.....	28
3.7.Нийгмийн дэг журмыг хангахад чиглэсэн стратегийн зорилтууд.....	29
Бүлэг IV.Эдийн Засгийн Салбарын Хөгжлийн Бодлого.....	30
4.1.Макро эдийн засгийн стратегийн зорилтууд.....	30
4.2.Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого.....	31
4.3.Уул уурхай, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн стратегийн зорилтууд.....	32
4.4.Хөдөө аж ахуйн хөгжлийн стратегийн зорилт.....	33
4.5.Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого.....	34
4.6.Зам, тээврийн хөгжлийн стратегийн зорилтууд.....	35
4.7.Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого.....	35
4.8.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого.....	36
Бүлэг V.Байгаль Орчны Тогтвортой Байдлын Бодлого.....	38
5.1.Байгаль орчныг хамгаалах бүтэц/Институтчлалын стратегийн зорилтууд.....	38
5.2.Агаарын бохирдлыг бууруулах стратегийн зорилтууд.....	39
5.3.Усны нөөцийг зохистой ашиглах стратегийн зорилтууд.....	40

5.4.Хөрс түүний бүрхэгч, ургамалын нөмрөг хамгаалах, нөхөн сэргээх стратегийн зорилтууд.....	41
5.5.Хог хаягдал оновчтой удирдлага бий болгох стратегийн зорилтууд.....	41
5.6.Ойжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилтууд.....	42
5.7.Биологийн олон янз байдлыг хамгаалах стратегийн зорилтууд.....	42
5.8.Гамшгаас урьдчилан сэргийлэх стратегийн зорилтууд.....	43
5.9.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийн зорилтууд.....	43
5.10.Цөлжилттэй тэмцэх стратегийн зорилтууд.....	43
5.11.Экологийн боловсрол олгох стратегийн зорилтууд.....	43
5.12.Хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн зорилтууд.....	44
Бүлэг VI.Хотын Хөгжлийн Бодлого.....	45
6.1.Хот төлөвлөлт, бүтээн байгуулалтын стратегийн зорилтууд.....	45
6.2.Амьдрах орчныг сайжруулах стратегийн зорилтууд.....	45
6.3.Тогтвортой хөгжлийн стратегийн зорилтууд.....	46
Бүлэг VII.Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийн Бүтэц Зохион Байгуулалт.....	48
7.1.Эрх мэдэл, үүрэг хариуцлага.....	48
7.2.Өмнөговь Хөгжлийн Сан	50
7.3.Усны Асуудал Эрхэлсэн Газар	50
7.4.Нийгмийн Хариуцлагын Түншлэл	51
7.5.Байгаль Орчныг Хамгаалан Тэтгэх Түншлэл	51
Бүлэг VIII.Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө.....	52
8.1.Хүн ам зүй, нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.....	52
8.2.Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.....	66
8.3.Байгаль орчны тогтвортой байдлын бодлогын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.....	75
8.4.Хот хөгжлийн бодлогын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө.....	85
Бүлэг IX.Дэд Хөтөлбөр, Төслийн Танилцуулга.....	90
9.2.Хүн ам зүй, нийгмийн хөгжлийн дэд хөтөлбөр, төслүүд.....	90
9.2.Эдийн засгийн хөгжлийн дэд хөтөлбөр, төслүүд.....	94
9.3.Байгаль орчны тогтвортой байдлын бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, төслүүд.....	102
9.4.Хот байгуулалтын хөгжлийн дэд хөтөлбөр.....	115
ХАВСРАЛТУУД.....	116-118

Товчилсон үгийн жагсаалт

СӨБ	-Сургуулийн Өмнөх Боловсрол
ИТХ	-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЕБС	-Ерөнхий Боловсролын Сургууль
МСҮТ	-Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төв
АЗДТГ	-Засаг Даргын Тамгын Газар
УУК	-Уул Уурхайн Компани
УИХ	-Улсын Их Хурал
ҮХЦБ	-Үндэсний Хөгжлийн Цогц Бодлого
МХЗ	-Мянганы Хөгжлийн Зорилт
НҮБ	-Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУБХҮБ	-Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал
ТХХТ	-Төр Хувийн Хэвшлийн Түншлэл
ОНХ	-Орон Нутгийн Төсөв
ӨХС	-Өмнөговийн Хөгжлийн Сан
УАЭН	-Усны Асуудал Эрхэлсэн Нэгж
НХТ	-Нийгмийн Хариуцлагын Түншлэл
БОХТТ	-Байгаль Орчныг Хамгаалан Тэтгэх Түншлэл
МАА	-Мал Аж Ахуй
ДНБ	-Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
БСШУЯ	-Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
ШУА	-Шинжлэх Ухааны Академи
БОАЖГ	-Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
ОНТ	-Орон Нутгийн Төсөв
УНТ	-Улсын Нэгдсэн Төсөв
БОАЖЯ	-Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
УХЭГ	-Усны Хэрэг Эрхлэх Газар
УМХЕГ	-Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
ХБХ	-Хөгжлийн Бодлогын Хэлтэс
ӨАБИ	-Өмнөговь Аймгийн Бизнес Инкубатор
ОУБ	-Олон Улсын Байгууллага
ОУБС	-Олон Улсын Байгууллагын Санхүүжилт
АЧУМА	-Агаарын Чанарын Улсын Мэргэжлийн Алба
УАХН	-Усны Асуудал Хариуцсан Нэгж
ТҮК	-Тохижилт Үйлчилгээний Компани
ӨАБСГ	-Өмнөговь Аймгийн Боловсрол Соёлын Газар
ӨАОБХ	-Өмнөговь Аймгийн Онцгой Байдлын Хэлтэс
ТАЗГ	-Тээвэр Авто Замын Газар
МХХГ	-Мэдээлэл Харилцаа Холбооны Газар

ӨМНӨТГӨЛ

Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр нь Монголын говийн бүс дэх уул уурхайн хөгжлийн гараан дээр шинэчилэн боловсруулагдаж байгаагаараа ихээхэн онцлогтой. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Говийн бүс гэсэн бүсчлэлийг шинээр гарган ирж, төрийн захиргааны төв болон олон улсын байгууллагуудаас олон шинэ санаачлагыг дэвшүүлж байна.

Өмнөговь аймаг нь Монголын Говийн бүсийн хөгжлийн тулгуур бүс нутаг төдийгүй уул уурхайн хөгжлийн томоохон төв болох нь гарцаагүй хэдий ч бүс нутгийн уул уурхайн салбарын өсөлт, нийгэм эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь бусад бүс нутагтай харьцуулахад олон онцлог шинжтэй.

Хүн амын суурьшил, хот байгуулалт болон уул уурхайн үйлдвэрлэлийг түшиглэсэн бизнес хөгжихийн зэрэгцээ, богино хугацаанд эрчимтэй явагдах хүн амын төвлөрөлийг даган нийгмийн үйлчилгээний хүртээмж муудах, хүн амын зохистой бүтэц алдагдах шинж ажиглагдаж байна. Мөн байгаль орчныг хамгаалах, түүнийг тэтгэх талаар ч ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс авч үзвэл уугуул иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орлого хуваарилалтын ялгааг арилгах, хүний хөгжлийг хангах талаар зохистой бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал юм.

Өмнөговь аймаг, түүний бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэс болгохын зэрэгцээ уул уурхайн хөгжлийн гараанд тулгуурлан нийгмийн хөгжлийг түргэтгэх, дэвшилд хүрэх зорилго агуулан боловсрууллаа.

Энэхүү хөгжлийн хөтөлбөр нь хөдлөшгүй зүйл биш бөгөөд цаг хугацааны хувьд өөрчлөгдөн буй нөхцөлд тохируулан өөрчлөн сайжруулж байх нь хөгжилд чиглэгдсэн бодлогын баримт бичгийг хэрэгжих боломжийг нэмэгдүүлдэг гэдгийг анхаарах нь зүйтэй.

Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар, түүний харьяа байгууллагууд, уул уурхайн томоохон компаниуд, бизнесийн байгууллагууд, иргэд, олон нийтийн байгууллагуудаас ихээхэн хүчин чармайлт шаардах нь гарцаагүй. Иймээс тус хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй танилцуулах, тэдний оролцоог хангахад анхааран ажиллах нь чухал.

Хөгжлийн хөтөлбөр нь нийгмийн дэвшил, эдийн засгийн хөгжилд хүрсэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд үйл хэргийг төлөвшүүлсэн байхаар төсөөлөгдөн гарсан баримт бичиг тул 2020 онд тулгуур зорилтуудаа биелүүлсэн, цаашид хөгжин дэвжих баттай тулгуур бий болгож чадсан байна гэдэгт итгэлтэй байна.

Говь нутгийн ард түмний наранд өргөх сүүн цацал нь өглөө бүр мэлтэлзэн байх болтугай

Хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг

2009.11.11

Улаанбаатар хот

Бүлэг I. Хөтөлбөрийн Концепц

Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөр нь 2020 он хүртэлх хугацаа, үүнээс эхний ээлжинд 2015 он хүртэл тус аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлсон боловч урт хугацааны (2020 оноос цааших) хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон, тогтвортой хөгжлийн урьдач нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн.

“Байгалийн баялаг- Сайн засаглал- Хөгжсөн Өмнөговь” аймгийн Хөгжлийн Хөтөлбөр нь Өмнөговь аймгийн хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг сайжруулах ерөнхий зорилгыг агуулахын зэрэгцээ уул уурхайн салбарт түшиглэсэн эдийн засаг, нийгмийн давшингуй хөгжлийн үзэл баримтлалд үндэслэсэн.

Иймээс орон нутгийн засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчин, хот байгуулалтын хүрээнд асуудлуудыг бичил бүсүүдийн хөгжлийн уялдаа, эдийн засгийн шүтэлцээнд суурилуулан авч үзлээ. Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрт төр хувийн хэвшлийн түншлэл, зах зээлийн механизмд суурилсан эдийн засгийн харилцаа, сайн засаглал, орон нутгийн бие даасан байдал зэргийг бүс нутгийн хөгжлийн тулгуур зарчим гэж үзлээ.

Өмнөговь аймаг нь Монголын Говийн бүсийн төв болон хөгжих ирээдүйтэй. Иймд аймгийн хөгжлийн хөтөлбөрийг цаг хугацааны хувьд гурван түвшинд төлөвлөсөн.

Нэг. 2010- 2015 онд уул уурхайн орд газруудыг ашиглах төслүүдийн бүтээн байгуулалт, суурь дэд бүтцийг байгуулах ажлыг хот байгуулалтын оновчтой бодлоготой уялдуулан хийж, хүн амын эрчимтэй төвлөрөл бүхий сууринд нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, орон нутгийн боломжит бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр хэрэглээг хангахад чиглэгдсэн бэлтгэл ажлууд голлон хийгдэнэ.

Хоёр. 2015-2020 онд уул уурхайн боловсруулах аж үйлдвэрлэл явагдахын хажуугаар бусад салбарт боломжит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх замаар биеэ дааж, нийгмийн үйлчилгээний чадавхи сайжран, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлууд хийгдэнэ.

Гурав. 2020 оноос хойш уул уурхайгаас бусад байгаль орчинд ээлтэй салбаруудын нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэл эдийн засгийн бүтцэд голлох байрыг эзэлж, бие даан баялагийг бий болгож, хүний хөгжлийг хангахад чиглэгдсэн ажлууд хийгдэнэ.

Өмнөговь аймгийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, түүний зарчмуудад үндэслэн гурван бичил бүсэд авч үзсэн. Бичил бүсүүдийн хөгжлийн загварууд нь харилцан адилгүй байх боловч нийтлэг шинжүүдээр нь авч үзвэл эдийн засгийн бүтэц болон бүс дэх үндсэн үүргүүдээрээ ялгагдана.

Өмнөговь аймгийн Төвийн бүс: Төвийн бүсийн тулгуур төв нь Даланзадгад хот байх бөгөөд тус хот бол Монголын Говийн бүсийн тулгуур төв хот байж нийгмийн суурь үйлчилгээний төв байхын зэрэгцээ соёлын болон оюуны томоохон төв болон хөгжих боломжтой.

Төвийн бүс нь эдийн засгийн бүтцийн хувьд ногоон үйлдвэрлэл, аялал жуулалчлал, түүнд зориулсан дэд бүтэц, эрчимжсэн мал аж ахуйн бүс болгохоор төлөвлөсөн. Уул уурхайн үйл

ажиллагааг нэмэгдүүлэхгүй байхын хамтаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөнө бодлого баримтлахаар төлөвлөж байна.

Өмнөговь аймгийн Зүүн бүс: Зүүн бүс нь уул уурхайн томоохон бүсчлэл болон хөгжинө. Бүлэг суурингийн таталцлын үүднээс авч үзвэл Өмнөговь аймгаас гадна Дорноговь аймагтай таталцалд орно. Зүүн бүс нь Цогтцэцийн, Ханбогд гэсэн хоёр тулгуур төвтэй байхаар төлөвлөсөн.

Тус бүсийн эдийн засгийн бүтэц нь уул уурхай, түүнд түшиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл зонхилон хөгжинө.

Өмнөговь аймгийн Баруун бүс: Баруун бүс нь уул уурхай ба аялал жуулчлалын хослон хөгжинө. Баруун бүсийн тулгуур төв нь Гурван Тэс сум. Баруун бүсийн нутаг дэвсгэрийн хойд хэсэг нь байгалийн цогцолбор газар бөгөөд түүнийг дагасан аялал жуулчлал хөгжүүлнэ. Харин өмнөд бүс нутаг нь ашигт малтмал олборлох, боловсруулах чиглэлээр ялгаран хөгжинө.

Бэлчээрийн мал аж ахуй зонхилж байсан бүс нутагт хүч түрэн орж ирж байгаа уул уурхайн салбар, түүнийг түшиглэсэн эдийн засгийн бүтэц бий болох нь тодорхой болж байгаа энэ үед эдийн засгийн бүтцийг сайжруулах үзэл баримтлалыг томъёолохдоо уул уурхайн хөгжлөөс ногоон үйлдвэрлэл, аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуй руу чиглүүлэхээр төлөвлөсөн.

Өмнөговь аймгийн эдийн засгийг урт хугацаанд уул уурхайн бус хүрээний нэмүү өртөг зонхилсон бүс нутаг болгон хөгжүүлж, уурхай хаагдах үед бие даан хөгжих бололцоог бий болгох нь чухал асуудал бөгөөд энэхүү хөтөлбөрийн нэг үндэслэл юм.

Сайн засаглал нь бүс нутгийн хөгжлийн суурь хүчин зүйлсийн нэг гэж үзэн орон нутгийн засаглалыг томъёолохдоо дараахь гурван хүрээнд авч үзсэн.

1. Орон нутгийн удирдах байгууллагуудыг чадавхижуулан, хөтөлбөрийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллах. Орон нутгийн сонгуулийн үр дүнд гарч ирсэн аливаа улс төрийн хүчин нь Өмнөговь Аймгийн Бүсчилсэн Хөгжлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг байх.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд одоо байгаа удирдлагын бүтцээс гадна зайлшгүй шаардлагатай бүтэц зохион байгуулалтыг бий болгож бичил бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрх олгох, үүрэг хүлээлгэх.
3. Орон нутгийн бие даасан байдал, ялангуяа санхүүгийн эрхийг баталгаажуулахад хуулийн хүрээнд эрчимтэй хамтран ажиллах.

1.1. Нийгмийн салбарын хөгжлийн үзэл баримтлал

1996 оны Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлогод хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.8 хувиас бууруулахгүй байх зорилт тавьсан билээ. Энэхүү бодлогын хэрэгжилт 2000 он хүртэл хэрэгжилт муутай байсан боловч 2004 онд УИХ-с хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн баталжсан бөгөөд үүнээс хойш УИХ болон Засгийн Газрын зүгээс “Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулийг баталж, “Хүүхдийн мөнгө хөтөлбөр” гэх зэрэг нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийг эрчимтэй явуулж эхэлсэн нь үр дүнгээ өгч 2006, 2007 онд нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2.07 болон 2.34 болж өссөн.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжих замаар 50 мянгаас доошгүй ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилт тавьсан байна. Энэ үүднээс ч Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжилийн хөтөлбөр нь хүний хөгжил, иргэдийн ажиллаж амьдрах, сурч боловсроход таатай эрүүл орчинг бүрдүүлэх тал дээр оновчтой зөв шийдлүүдийг авч хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно.

Хүн ам зүй, нийгмийн хөгжлийн стратеги хөтөлбөрийг боловсруулахдаа цаг хугацаагаар нь хоёр төрөлд буюу богино (2009-2015) ба дунд (2015-2020) хугацаанд авч үзэж, уг хөтөлбөрт тусгасан болно. Энд хөтөлбөрийг боловсруулахад суурь болгон авч үзсэн таамаглалууд, эдгээрийн учир шалтгааныг тайлбарлаж, дараагаар нь Өмнөговь аймгийн хүрээнд тулгамдаж буй болон ирээдүйд учирч болох асуудлуудыг тодорхойлсон. Уг асуудлуудыг тодорхойлсны дараагаар гарч болох асуудлуудыг шийдэх арга замыг нарийвчлан боловсруулсан болно.

1.2. Эдийн засгийн хөгжлийн үзэл баримтлал

Хувийн хэвшлийг дэмжих зарчим: Үйлдвэрлэлийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог эрчимтэй нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, эдийн засгийн чөлөөт өрсөлдөөний ижил нөхцөлийг бий болгох.

Чөлөөт зах зээлийн механизм бүрдүүлэх зарчим: Аливаа үйлдвэрлэл худалдааны чиглэлд монополь байдал мөн хэрэглэгчээс хараат байдлыг үл тэвчих, үйлдвэрлэлийн өртөгт тулгуурласан худалааг бус индексжүүлсэн үнийн бодлогыг баримтлах.

Хүний нөөц бүрдүүлэх зарчим: Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүний нөөц бүрдүүлэх, одоо байгаа судалгааны лабораторийн чадавхийг урьдчилан бий болгох.

Бодлогын уялдааг хангах зарчим: Уул уурхайд түшгэлсэн үйлдвэрлэл, уул уурхайгаас хараат бус үйлдвэрлэл, гадаад худалдааны чиглэлүүдийг үечлэлтэйгээр улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандалага, бүсчилсэн болон орон нутгийн хөгжлийн онцлог болгон бусад хөтөлбөрүүдийн зорилтуудтай уялдуулах.

Хамтын ажиллагааны зарчим: Олборлох, боловсруулах, худалдах үе шатууд дахь үйлдвэр байгуулах, шинэ технологи нэвтрүүлэх аливаа төслийг хэрэгжүүлэхдээ олон улсын байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, дэмжигч, сонирхогч талуудын хамтын ажиллагаа, харилцан ашигтай түншлэлд тулгуурлах.

Удирдлагын зарчим: Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг гүйцэтгэх Засаг дарга болон түүний ажлын баг /тамгын газар/, ИТХ, төрийн бус байгууллагууд, хувийн сектор, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, сургалт судалгааны болон олон улсын байгууллага зэрэг хөтөлбөрийг дэмжигч, сонирхогч талын төлөөллийг оролцуулсан дундын оновчтой бүтэц бий болгохыг дэмжих.

Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь орлогын төвлөрөл, хуваарилалт хаана хурдацтай явагдаж байгаагаас шалтгаалан нөөцийн дахин хуваарилалтад нөлөөлж байдаг. Энэхүү циклийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлт бууралтад нөлөө үзүүлдэг.

Ойрын арван жилийн хугацаанд Монгол улсын макро эдийн засгийн бүтэц хурдацтай өсөхтэй зэрэгцэн Говийн бүсийн эдийн засагт үсрэнгүй өсөлт бий болохоор байна. Энэ нь Монгол улсын макро эдийн засгийн асуудал төдийгүй бүс нутаг цаашилбал олон улсын хэмжээний хөрөнгө оруулалтын усргал, өндөр түвшний технологийн нэвтрэлт хурдацтай явагдсанаар эдийн засгийн бүтэц өөрчлөгдөх шалтгаан болно.

1.3. Байгаль орчны тогтвортой байдлын үзэл баримтлал

Байгаль орчныг хамгаалах бодлогын үндэс нь Төрөөс Экологийн Талаар Баримтлах Бодлого, Биологийн Төрөл Зүйлийг Хамгаалах Хөтөлбөр, Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Үндэсний Хөтөлбөр, Монгол Улсын XXI Зууны Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр Болон Усны, Хог Хаягдалын, Агаарын, Озоны Үе Давхаргыг Хамгаалах, Уур Амьсгалын Өөрчлөлтийн, Ойн, Цөлжилтийн, Ногоон Хэрэм, Цоохор Ирвэс, Цагаан Тоос, Удаан Задардаг Органик Бохирдуулагчийн, Идлэг Шонхорыг Хамгаалах, Аргаль Хонийг Хамгаалах зэрэг үндэсний хөтөлбөрүүд болно. Түүнчлэн Өмнөговь Аймгийн Байгаль Орчны Мастер Төлөвлөгөө, Өмнөговь Аймгийн Ус Дэд Хөтөлбөр болон бусад орон нутгийн бодлого, шийдвэрүүд нь Бүсчилсэн Хөгжлийн Хөтөлбөрийн байгаль орчныг хамгаалах бодлогын үндэслэл болсон.

Байгаль орчны орон нутгийн удирдлагын загвар нь төрөөс экологийн талаарх баримтлах бодлогод тулгуурлах бөгөөд экологи, эдийн засгийн, засаг захиргааны бүсчилэл болон тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг харгалзан байгалийн төрөл бүрийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны унаган төрийг хамгаалах асуудлыг бүс нутгийн хүрээнд цогцолбороор шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ, мэдээлэл ил тод байдлын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Говийн бүс, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт ойрын ирээдүйд том ба дунд хэмжээний 10 уул уурхайн төсөл хэрэгжинэ. Энэ нь уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл өндөр болно. Тухайлбал цөлжилт, тоосжилт, шар шороон шуурга, ургамалын нөмрөгийн хомсдол үүсэх, зэрлэг ан амьтадын бэлчээр нутаг хомсдох, хөрсний бохирдол, усны хомсдол үүсэх зэрэг болно. Ийм онцгой нөхцөл байдал байгаль орчны хамгаалалт, говь цөлийн бүсийн экосистемийн тэнцвэрийг хангахад илүү нарийвчилсан бодлого, төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хяналт мониторингийн механизмыг шаардаж байна.

Өмнөговь аймгийн аль ч бүс нутагт байгалийн баялагыг ашиглаж байгаа нөхцөлд тухайн орон нутгийн байгаль орчинд эерэг нөлөө үзүүлдэг байх, хөгжлийн сангаар дамжуулан ойжуулах, цэцэрлэгжүүлэх, усжуулах хөтөлбөрүүдийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлдэг байх. Байгалийн нөөцийг ашиглагч нь нөхөн сэргээгч байдаг зарчим бий болгох.

Өмнөговь Аймгийн Байгаль Орчны Мастер Төлөвлөгөөнд заагдсан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцвэртэй уялдуулах, өнөө болон ирээдүй хойч үеийнхний эрх ашгийн үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэхэд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын чармайлт, тэмцэл, санаачлагын чиглүүлэх гэсэн зорилго, бодлоготой байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг уялдуулах.

Говийн бүсийн экологийн тэнцлийг хангах, хүний хүрээлэн буй орчинг эрүүл аюулгүй байлгах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүний буруутай үйл ажиллагаа болон уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах гэсэн шаардлагууд нь Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийг гурван бүсэд хуваах, төвийн

бүсэд байгальд ээлтэй, цэвэр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй байх гэсэн зорилтууд дэвшүүлэхэд хүргэж байна.

Баруун бүсэд аялал жуулчлал, уул уурхайн салбарыг түлхүү хөгжүүлэх бол зүүн бүсэд уул уурхайн, түүнд тулгууралсан салбарыг тэргүүлэх ач холбогдолтойгоор хөгжүүлэхээр Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрт тусгасан.

1.4. Хотын хөгжлийн үзэл баримтлал

Хот байгуулалтыг цаг хугацааны үечлэлээр богино болон дунд хугацаанд авч үзэн хөтөлбөрт тусгаж байгаа бөгөөд энэ нь хотын хөгжлийн урт хугацааны төсөөлөлд үндэслэгдэн, тогтвортой хөгжлийн үндсийг бий болгохыг зорьж байгаа болно.

Бүс дэх суурин газруудын хөгжлийн бичил бүсийн тулгуур төвүүд, түүний дагуул суурин гэсэн хоёр үндсэн бүлэгт авч үзлээ. Бүсийн тулгуур төвүүд нь эдийн засгийн хөгжлийг дагалдан бий болох томоохон суурин газрууд бөгөөд шилжин ирэгсэд хамгийн өндөр байх юм.

Хотын хөгжлийг хүний тав тухтай орчиныг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөг хамгийн бага байх, эрчимтэй хотжилт гэсэн хурдацтай өөрчлөлтийн үзэл баримтлалд тулгуурласан болно.

Бүлэг II. Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийн Үндэслэл

Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөр нь Монгол улсын үндэс хууль, Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Бүсчилсэн хөгжлийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, Монголын мянганы хөгжлийн зорилт, Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан үндэсний хөгжлийн цогц бодлого, Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр/Өмнөговь аймгийн ИТХ-ын 2005 оны VII сарын 3/2 дугаар тогтоолоор батлагдсан/ болон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагуудаас улсын, бүсийн, орон нутгийн хөгжилтэй холбогдон гаргасан тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөрүүдэд үндэслэсэн болно.

Өмнөговь аймгийн дотоод бүсчлэл тогтоох, бүсүүдийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох, нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлогыг томъёолох, хот байгуулалтын төлөвлөлт, байгаль орчныг хамгаалах бодлогыг төлөвлөхдөө Монгол улсын хуулиуд(15), үндэсний хөтөлбөр, хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн төслүүд(25), нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагын тогтоол, шийдвэрүүд(20), олон улсын байгууллага, хувийн хэвшлээс Монголын говийн бүс, Өмнөговь аймгийн хөгжлийн асуудлаар гаргасан судалгаа, зөвлөмжүүд(25), нийт 80 гаруй хууль, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, судалгаа, зөвлөмжүүдийг судлаж Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрт холбогдох үзэл санаа, зарчим, чиглэлүүдийг тусгасан.

Монгол улсын Төвийн бүсийн хөгжлийг түргэтгэхэд Монголын Говийн бүс гэсэн шинэ бүсчлэл эсвэл төвийн бүсийн бичил бүсчлэлийн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Тус бодит шаардлагыг хангах үүднээс ойрын ирээдүйд Монгол улсын Засгийн газраас өмнө нь батлагдсан таван бүс дээр нэмж Говийн бүсийн статусыг баталгаажуулна. Говийн нутагт ойрын 5-аас 10 жилийн хугацаанд 10 гаруй уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлийн төслүүд хэрэгжиж, нийтдээ 80 мянган гаруй хүн амтай 4-6 хот, суурин байгуулагдах төлөвтэй байна.

Говийн бүс нутаг, Өмнөговь аймагт уул уурхайн хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлтийг дагалдсан эдийн засгийн өндөр өсөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнээр аймгийн болон Говийн бүс нутгийн жөгжилд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ байгаль орчин, нийгэм соёл, хүний хүрээлэн буй орчинд тодорхой эрсдэл учруулна. Тухайлбал Монгол улсын хамгийн том нутаг дэвсгэртэй, хүн ам нь хамгийн сийрэг аймгийн өнөөдрийн түвшнээс уул уурхайн хайгуул олборлолт, боловсруулах хүнд аж үйлдвэр хөгжсөн хүн амын төвлөрлөөрөө Монгол улсад эхний дөрөвт багтах аймаг болон хөгжих хугацаанд аймгийн нийгэм соёл, говь цөлийн экосистем, хүний хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц аюул занал бий болно.

Иймд Өмнөговь аймгийн хэмжээнд өнөөдөр тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, 2020 он хүртэл тулгарч болох сорилт, хүндрэл бэрхшээлийг гэтлэн давах, үүсэх эрсдэл, аюул заналаас урьдчилан сэргийлэх зэрэг нийтлэг шаардлагуудаас үүдэн Өмнөговь аймгийн хөгжлийн үзэл баримтлал, аймгийн бичил бүсчлэл, хот байгуулалт, нийгэм эдийн засгийн хөгжил, байгаль орчныг хамгааллын бодлогыг илүү өргөн хүрээнд, урт хугацаанд шинэчилэн төлөвлөх хэрэгтэй.

2005 онд аймгийн ИТХ-аар батлагдсан Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь уул уурхайн ашиглалтаас үүдэн гарах урт хугацааны сөрөг нөлөөллүүдийг

арилгах, байгаль орчныг хамгаалах бодлогыг орхигдуулсан. Түүнчлэн эдийн засгийн өсөлтийг нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг тулгуурлах боловч урт хугацаанд ногоон үйлдвэрлэл, мэдлэг шингээсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал зэрэг салбарт тулгуурлан хөгжих тогтвортой хөгжлийг чиг баримжааг анхаараагүй байна.

Иймд Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөрийг дээрх дутагдлуудыг нөхөх, өнөөгийн ба ирээдүйн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхүйц зөв бодлого тодорхойлсон байхаар боловсруулахыг чухчилсан.

Монголын төрөөс улсын, бүсийн, аймгийн, сумын түвшинд ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, дэд бүтэц, үйлдвэрлэл хөгжүүлэх, хот суурин газруудын хөгжлийг түргэтгэх болон бүсчилэн хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг орон нутгийн түвшинд оновчтой хэрэгжүүлэх, төрөөс баримталж буй бодлого, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдуулан төлөвлөлтийг боловсронгуй болгож ажиллах нь зайлшгүй юм.

Уул уурхайн хайгуул, олборлолт, боловсруулалт тээвэрлэлттэй уялдсан дэд бүтцийн салбарын хөгжил зэрэг нь Өмнөговь аймгийн хот орчмын болон бэлчээрийн газрын менежментийг шинэчилэн төлөвлөхийг шаардаж байна. Энэхүү шаардлага нь Өмнөговь аймгийн дотоод бүсчлэл, түүний хилийн цэс, бүсүүдэд мөрдөх дэглэмийг тогтоох суурь хүчин зүйлс юм.

2.1. Хүн ам зүй, нийгмийн хөгжлийн бодлогын үндэслэл

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр, бүсчлэлийн үзэл баримтлалын дагуу дөрвөн томоохон суурин байгуулагдахаар төсөөлөгдөж байна. Эдгээр суурингууд нь бүсчлэлийн хувьд гурван бүсэд хуваагдахаар энэхүү хөтөлбөрт тусгагдсан болно.

Хүснэгт-2.1: Бүс, бүсийн тулгуур төв, бүлэг суурингууд

Бүсчлэл	Тулгуур төв	Бүлэг суурингууд
Баруун бүс	Гурван тэс	Ноён, Сэврэй
Төвийн бүс	Даланзадгад	Номгон, Хүрмэн, Баяндалай, Ханхонгор, Булган, Мандал Овоо, Цогт Овоо
Зүүн бүс	Ханбогд, Цогтцэций	Манлай, Баян Овоо

Эндээс таамаглалуудыг хооронд нь харьцуулж үзэж, ирээдүйд уг бүс нутагт уул уурхайг даган хэт өндөр механик шилжилт явагдах өндөр магадлалтай харгалзан бодолцсоны үндсэн дээр АХБ-ны хийсэн хүн ам зүйн таамаглал тооцоог энэхүү хөтөлбөрийн хүрээнд гол чиглэлүүдийн нэг гэж үзсэн.

Хот суурин газрын энэхүү өөрчлөлт нь хүн ам зүй, нийгмийн хөгжлийн бодлогыг боловсруулахад нэг чухал үндэслэл болсон. Бүлэг суурингийн тогтолцооны өөрчлөлт нийгмийн суурь үйлчилгээг жигд хүртээх бодлогыг Өмнөговь аймгийн түвшинд томъёолоход онцгой нөлөө үзүүлж байна.

2.1.1. Нийгмийн салбарын тулгамдсан асуудал,
ирээдүйд үүсч болох хүндрэлүүд

Хүснэгт-2.2: Нийгмийн салбарын тулгамдсан асуудлууд

Асуудлууд	Нөлөөлөгч гол хүчин зүйлс
Хүйсийн тэнцвэрт харьцаа алдагдах	Уул уурхайн хөгжлийг дагаж, ажлын байр нэмэгдэх бөгөөд уул уурхайн салбарт дийлэнх нь эрэгтэйчүүд ажиллах тул орон нутгийн бус мэргэжилтэнгүүдийн шилжилт хөдөлгөөний дүнд хүйсийн тэнцвэрт байдал алдагдах
Нэг хүнд оногдох нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж муудах	Хотжилт эрчимтэй явагдсанаар төвлөрөл үүсч, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж хүрэлцэхгүй байх
Хүнсний аюулгүй байдал алдагдах	Хүнсний хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр хилийн боомтоор чанарын баталгаагүй, хямд үнэтэй бүтээгдэхүүн орж ирэх, чанарын баталгаатай бүтээгдэхүүний нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлөх
Хүн амын ундны усны шаардлага хангахгүй усыг өргөнөөр хэрэглэх	Аймгийн сумдын хүн амын ундны усны хатуулаг зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх
Ажилгүйдлийн түвшин нэмэгдэх	Механик шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хөдөлмөрийн зах зээл дээр орон нутгийн иргэдийг шахах, суурин бус ажилчдыг шинээр үүсэх ажлын байруудад хүлээж авахын хажуугаар өмнөх өрсөлдөөн бага байсан орон тоонд өрсөлдөөн үүсэх, уул уурхайн хөгжлийг даган ажил хайсан ажилгүй иргэд олноор шилжин ирэх
Ядуурал нэмэгдэж, газар авах	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн ган, зуд, гэнэтийн байгалийн гамшиг учрах, уул уурхайн хөгжлийг дагаад орон нутгийн эдийн засагт хэрэглэгчийн үнийн индексийн өсөлт нь бусад салбарт ажилладаг хүмүүст үнийн дарамт учруулах
Боловсон хүчний нөөц дутагдах	Орон нутагт нийгмийн үйлчилгээг хүргэх мэргэжилтэнгүүд дутагдах, тус салбарын мэргэжилтнүүдийг бусад бүс нутгаас татан авчрах бололцоо бага байх
Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй байх	Механик болон цэвэр өсөлтийн дүнд хүн амын өндөр өсөлт бий болж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар буурах, төрийн оролцоо хэт давамгайлснаас үүдэн өрсөлдөөн буурч чанар муудах
Нийгмийн үйлчилгээний нэмэлт зардлуудын эх үүсвэр тодорхойгүй, хүрэлцэхгүй байх	Нийгмийн үйлчилгээг өргөтгөж, оршин суугчдыг хамруулахад гарах нэмэлт зардлуудын эх үүсвэр тодорхойгүй хэвээр байх
Төвлөрсөн суурин хөгжиж, хүн ам нэмэгдэж байгааг дагаад гэмт хэргийн тоо өсөх	Нэмэлт ажлын байрыг даган олон газрын хүмүүс ирж суурьшиж болох тул үүнтэй зэрэгцэн гэмт хэргийн тоо өсөх, нийгмийн хэв журмыг сахиулах хүчний байгууллагын хүчин чадал дутах
Соёлын өв мартагдаж, алга болох	Шилжилт хөдөлгөөн ихэд явагдсанаас өв уламжлагдсан ёс заншил алдагдах, соёлын өндөр ач холбогдолтой эд зүйлсийг тонох, хулгайлах

2.1.2. Нийгмийн салбарын хүндрэлүүдийг шийдвэрлэх арга зам

Хүн ам зүйн чухал элемент бол хүн ам зүйн насны бүтэц байдаг. Монгол улсын хүн ам ерөнхийдөө залуу насны бүтэцтэй байснаа идэрших бүтэц рүү шилжиж байна. “Судлаачдын үзэж байгаагаар энэ хандлага 2020 он хүртэл үргэжлэх төлөвтэй байна.”¹ Тийм ч учраас нийгмийн хөгжлийн бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд аль насны бүлгийг зорилтот бүлгээр авах вэ гэдэг чухлаар тусгагдана. Ялангуяа тулгуур төвүүдэд суурьших хүн амыг ирээдүйд дайжин шилжих хөдөлгөөнд оруулахгүй байх талаас нь ажиллахын тулд тухайн насны бүтцийн сонирхолыг харж үзэх хэрэгтэй.

Хотын Ядуурлын Тайланд² дурдсанаар бол цаг хугацаа өнгөрөхийн хэрээр шилжих хөдөлгөөний шалтгаан нь боловсрол эзэмшихээр шилжин нүүхээс илүүтэй, ажлын байр илүү олддог, илүү амьдрах орчин, зах зээлд ойрхон зэрэг эдийн засгийн хүчин зүйлс болж хувирсан байна. Эндээс харахад шилжилтийн хэв шинж нь эдийн засгийн боломж сайтай байршлыг хүмүүс илүүтэй сонгох болсныг илэрхийлж байна. Уул уурхайн салбар түлхүү хөгжих өндөр потенциалтай гэдэг утгаараа Өмнөговийн аймгийн хувьд, хүмүүсийн амьдрах орчинг таатай бүрдүүлж чадвал дээр дурьдсан олон асуудлууд шийдэгдэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Амьдрах орчин бол зөвхөн байр орон сууцаар зогсохгүй бөгөөд үүнтэй дагалдах нийгмийн болон бизнесийн үйлчилгээний салбарын хөгжил зэргийг давхар оруулж байгаа ойлголт болно.

Нэгэнт уул уурхай бол урт хугацааны тулгуур салбар байж чадахгүй учир, ирээдүйд уул уурхайн нөөц баялаг дуусахад хүн амын тогтвортой суурьшилтыг баталгаажуулах үүднээс эхний шатнаас авахуулан уул уурхайн компаниудтай нягт хамтран ажиллах хэрэгтэй. Хэдийгээр Өмнөговь аймгийн хэмжээнд цаг хугацааны богино үечлэлд аваад үзэхэд уул уурхайг даган үүсэх хөдөлмөрийн хэрэгцээг хангахад Өмнөговь аймгийн хүн амын механик өсөлт зайлшгүй шаардлагатай байгаа.

2.2. **Байгаль орчны тогтвортой байдлын бодлогын үндэслэл**

2.2.1. Тулгамдсан асуудлууд

Байгаль орчныг хамгаалах, байгаль орчны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, биологийн олон янз байдлыг хамгаалах, экологийн тэнцвэрийг хадгалах зэрэг чиглэлд 30 гаруй хууль, 14 олон улсын протокол, конвенци, гэрээ болон УИХ, Засгийн газраас батлан гаргаж даган мөрдөж буй 27 тогтоол, төсөл, хөтөлбөрүүд байгаа нь чамлахааргүй тоо боловч бодит байдалд тэдгээрийн хэрэгжилт сул, орон нутгийн идэвхи оролцоо хангалтгүй байсан хэвээр байна.

2.2.2. Уур амьсгалын өөрчлөлт

Говийн бүс, Өмнөговь аймгийн хэмжээнд жилийн дундаж температур олон жилийн дунджаас илүү нэмэгдэж, хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилох болсон.

2.2.3. Цөлжилт, элсний нүүдэл, шар шороон шуурга

Говь, цөлийн бүсийн эко-систем нь эмзэг, нөхөн сэргээгдэх хугацаа урт, ургамалын нөмрөг ядмаг байхаас гадна цөлжилт, элсний нүүдэл нэмэгдэж, шар шороон, ган зудны давтамж нэмэгдсэн. Цөлжилтэд уур, амьсгалын өөрчлөлт, ургамалын нөмрөгийн хомсдол, бэлчээрийн даац хэтрэх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэл зонхилон нөлөөлж байна. Монгол орны хуурай голдуу бүс нутгийн 228,750 мянган га талбай цөлжсөн

¹ Монголын Хүний Нөөцийн Институт, “Хүн ам зүйн урамшууллаа эдийн засгийн өсөлтийн түлхүүр хүчин зүйл болгон ашиглая”, 2009

² НҮБ, 2004

байна.Бэлчээрийн 70 орчим хувь ямар нэг хэмжээгээр цөлжилтөнд өртсөн.Үүний дотор газар нутгийн 41,3 хувийг эзлэх цөлийн хээр, цөлийн бүсийн 56,6% дунд ба хүчтэй цөлжилтөнд өртсөн байна.

2.2.4.Ногоон байгууламжийн хүрээ, хил хязгаарыг нэмэгдүүлэх

Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж тоорой, хайлаасны төгөл, заган ой хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа өнөөгийн экологийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.

2.2.5.Усан хангамжийн эх үүсвэрийн нөөц, түүний ашиглалт, хомсдол

Гадаргуугийн урсацгүй, агаарын хур тундас маш бага унадаг энэ бүс нутгийн ус хангамжийн ганц эх үүсвэр нь газар доорх ус. Монголын говийн бүсийн газар доорх усны нөөцийг бүрэн судлаагүй байна. Газар доорх усны нөөц, тэжээлийн горим, авч ашиглах зохистой хэмжээ зэргийг нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийх. 2008 оны байдлаар Баян-Овоо, Ханбогд, Манлай, Цогтцэций, Цогт-Овоо, Мандал-Овоо, Булган, Хүрмэн зэрэг сумдад усны эрдэсжилтийн үзүүлэлтэд зөвшөөрөгдөх хэмжээнээс 10мг/л-ээс 380мг/л хүртэл хэмжээгээр илүү байна.

2.2.6.Хөрсний бохирдол, эвдрэл, тоосжилт

Өмнөговь аймгийн Ханбогд, Гурвантэс, Цогтцэций, Баян-Овоо, Цогт-Овоо, Манлай зэрэг сумын нутагт мөнгөн ус болон мышьякийн бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан Цогтцэций, Гурвантэс, Ханбогд, Манлай зэрэг сумын нутагт тоосжилт өндөр, газрын эвдрэл их болсон.

2.2.7.Ургамалын нөмрөг хомсдох

Говийн бүс, Өмнөговь аймгийн нутагт дэвсгэрт хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхай олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэл болон бэлчээрийн даац 7 суманд хэтэрсэн зэрэг нь ургамалын нөмрөг хомсдох үндсэн шалтгаан болж байна. Заг, сондуул, харгана, буйлс зэрэг олон наст ургамлуудыг түлшинд ихээр хэрэглэдэг.

2.2.8.Хулан, цагаан зээр, хар сүүлт

Өмнөговь аймгийн Хүрмэн, Ноён, Номгон, Баян-Овоо, Ханбогд, Манлай зэрэг сумын нутгаар идээшлэн, нүүдэлдэг байсан хулан, цагаан зээр, хар сүүлтийн популяци нь ган зуднаас үүдэлтэй бэлчээрийн хомсдол, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн олборлолт, хайгуул, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс шалтгаалан Дорноговь аймгийн зэргэлдээ сумын нутаг руу нүүдэлсэн.

Дэлхий нийтэд Төв азийн цөлийн өмнөд хэсэг /Альшаа говь, Алтайн өмнөд говь гэх мэт / гэж нэрлэгдсэн дээрхи сумдын нутаг дэвсгэр, Дорнодоос Баянхонгор, Говьалтайгаар дамжин Казакстан хүртэл нүүдэллэн амьдардаг байсан хулан, хар сүүлт, цагаан зээрийн том хэмжээний сүргүүд нь орос хятадыг холбосон ... онд байгуулагдсан одоо ашиглагдаж байгаа төмөр замаар бүрэн таслагдсан билээ. Цаашид шинээр тавигдахаар төлөвлөгдөж байгаа Тавантолгой-Гашуун сухайт хүртэлх төмөр болон хар замууд нь эдгээр зэрлэг амьтдын болон түүнийг даган амьдардаг махчин амьтдын хувьд ч хязгаарлагдмал байдлыг үүсгэх болно. Үүнд хандсан байгаль орчны нарийвчилсан үнэлгээ судалгааг дэлхийн жишигт нийцсэн түвшинд гүйцэтгэх шаардлагатай.

2.2.9.Нүүдлийн шувууд

Говь гурван сайханы орчим хийсэн судалгаагаар уг нутаг дэвсгэрт 11 багт багтах 29 овгийн 134 шувуу байдгийг тогтоожээ. Үүний 31 нь суурин, 103 нь нүүдлийн шувууд аж. Нүүдлийн шувуудаас 63 нь өндөглөдөг, 32 нь дайрч өнгөрдөг, 2 нь өвөл орж ирдэг, ба үлдсэн 6 нь тохиолдлын байдлаар орж ирдэг. Монгол орны бусад бүс нутгуудад нүүдлийн болон суурин шувууд, тэр дундаа махчин шувуудын олноороо цахилгаан дамжуулах агаарын шугам дээр сууж

цахилгаанд дохиулан үхдэг. Баяновоо Ханбогд сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх замууд уул уурхайн суурин байгууламжууд үйлдвэрлэл нь тэнд цөөн тоогоор амьдарч байгаа дэлхийд нэн ховордсон, дэлхийн болон Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн Жороо тоодог /-Horbary Bustard-/ , Хулан жороо /-Mongolian Graund Jay-/ зэрэг шувуудын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөхийг нарийвчлан тооцох шаардлагатай.

2.2.10. Ирээдүйд үүсч болох хүндрэлүүд

2015 он хүртэл Монголын говийн бүс нутагт хүн амын эрчимтэй төвлөрөл бий болж, уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, хот суурин газруудын тэлэлт явагдана.

Уул уурхайн салбарын хөгжил Өмнөговь аймгийн эдийн засгийн бүтэцд үнэмэлэхүй хувийг эзлэх боловч говь цөлийн бүсийн экологийн тэнцвэр алдагдуулах, хүний хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байдлыг хязгаарлахаас гадна тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг сааруулахуйц хүндрэлүүд үүсч болно.

Байгаль орчны асуудлууд нь аймгийн болон улсын хил хязгаараас үл хамааран нийтлэг шинж чанартай. Энэ нь Монголын говийн бүс нутгийн байгаль хамгааллыг асуудалд хөрш зэргэлдээ аймгууд, хөрш зэргэлдээ орнуудын анхаарлыг хандуулахад онцгой чухал ач холбогдолтой.

Говийн бүсийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлд өнөөдрийн хэрэгжүүлж буй системгүй, хоорондоо уялдаа муутай санаачилга, төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангаж, говийн бүсэд багтаж буй аймгуудын хүчин чармайлтыг нэгтгэх асуудал тулгамдаж байна.

2.3. Хот байгуулалтын бодлогын үндэслэл

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр, бүсчлэлийн үзэл баримтлалын дагуу дөрвөн томоохон суурин байгуулагдахаар төсөөлөгдөж байна. Хүн амын нягтаршлаар нь авч үзвэл дараахь байдалтай байна.

Хүснэгт-2.3: Тулгуур төв хотуудын хүн ам

Хотын хүн ам	2015	2020
Даланзадгад	25 000 хүн	30 000 хүн
Ханбогд	18 000 хүн	25 000 хүн
Цогтцэций	18 000 хүн	25 000 хүн
Гурван тэс	8 000 хүн	10 000 хүн
Нийт	75 000 хүн	90 000 хүн

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бичил бүсүүдийн төвүүдийг хөгжүүлэх нь тухайн бүс доторхи таталцлыг идэвхжүүлдэг. Хотын хүн амын өсөлтийг даган цаг хугацааны үечлэлээр нь хот байгуулалтын тулгамдсан асуудлууд нь харилцан адилгүй байна. Хөтөлбөрт 2015 он хүртэл богино, 2020 он хүртэл дунд, 2020 оноос хойш буюу урт хугацаа гэсэн цаг хугацааны үечлэлүүдийг авч үзэж байна. Богино, дунд хугацаанд тулгамдах асуудлуудыг илрүүлэх, гарах арга замыг тодорхойлохын зэрэгцээ урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэгдсэн зорилтуудыг тусгаж байна.

Тулгамдсан асуудлууд болон ирээдүйд гарч болох хүндрэлүүдийг цаг хугацааны үечлэлээр авч үзвэл дараахь байдалтай байна.

2.3.1. Хот байгуулалтын тулгамдсан асуудлууд болон ирээдүйд үүсч болох хүндрэлүүд /2015 он хүртэл/

Хүснэгт-2.4: Хот байгуулалтын хүрээнд тулгамдсан асуудлууд(богино хугацаа)

Тулгамдсан асуудлууд	Нөлөөлөгч гол хүчин зүйлс
Сумын хүн амын өсөлтийн хүчин зүйлсүүд тодорхойгүй	Хотын хүн амын өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйл нь томоохон уул уурхайн компаниудын хүний нөөцийн болон худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлт
Хөдөөгийн 12 сумдад дунд болон урт хугацаад баримтлах хөгжлийн хөтөлбөр боловсруулагдаагүй	Сумын хөгжилд шууд нөлөөлөх эдийн засгийн бүтэц тодорхойгүй
Одоогийн хийгдсэн ерөнхий төлөвлөгөө болон хот байгуулалтын баримт бичгүүд хүн амын өсөлттэй уялдаагүй	Хот төлөвлөлтийн бичиг баримтууд нь хүн амын нягтаршлыг зөв тооцоогүй, зарим сумдын хувьд ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголт хийгдээгүй
Даланзадгадаас бусад суурин газарт инженерийн шугам сүлжээ байхгүй	Одоогийн хүн ам нь дэд бүтэц байгуулах хэмжээнд хүрээгүй, мөн орон нутгийн зүгээс инженерийн дэд бүтэц хийх бололцоо байхгүй
Орон нутагт хот байгуулалтын институт байхгүй	Нийтийн аж ахуйн газар, хог хаягдлын менежмент зэргийг хариуцсан газар байхгүй
Сумдад хот байгуулалтын асуудлыг мэргэжлийн бус хүн хариуцаж ажиллаж байна.	Орон нутагт хот байгуулалтын боловсон хүчний нөөц дутагдалтай
Хот байгуулалтын хүрээнд инженерийн шугам сүлжээг барьж байгуулах санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	Улсын болон орон нутгийн төсөв, хувшийн хэвшлийн хөрөнгө оруулалтын талаар тодорхой шийдэл гаргаагүй
Хот байгуулалтын салбарт төр хувийн хэвшлийн түншлэл хөгжөөгүй	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн үр ашигтай байх орчин бүрдээгүй
Ус, дулаан, цахилгааны зэрэг хэрэглээний үнэ нь зах зээлийн механизмаар шийдэгддэггүй	Ус, дулааныг нийлүүлэх, хог хаягдлыг боловсруулах зардалтай тэдгээрийн үнэ нь уялдаагүй

2.3.2. Хот байгуулалтын тулгамдсан асуудлууд болон ирээдүйд үүсч болох хүндрэлүүд /2015-2020 он хүртэл/

Хүснэгт-2.5: Хот байгуулалтын хүрээнд тулгамдсан асуудлууд(дунд хугацаа)

Хот орчмын хүрээлэн буй орчны бохирдол ихсэх	Хотын ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдлын хэмжээ нэмэгдэх
Хот орчмын газар зохион байгуулалтын асуудлууд хүндрэх	Бэлчээр, хот байгуулалтын зориулалттай газар нутгийг зааглах боломж
Хотын дэд бүтцийн урсгал засвар хийх шаардлага урган гарах	Нийтийн аж ахуйн газарын санхүүгийн чадамж, эдийн засгийн үр ашигтай үйл ажиллагаа
Хотын дулааны болон усны хэрэглээ нэмэгдэх	Хүн амын өсөлт, орон сууцжих явц
Газрын хомсдол үүсэх	Хот байгуулалтын нөөц газруудын хүрэлцээ
Хотын уугуул суурьшмал амьдралтай иргэдийн өрхийн орлого буурах	Уугуул оршин суугчдын орлогын эх үүсвэр нэмэгдэхгүй байх

2.3.3. Хот байгуулалтын тулгамдсан асуудлууд болон ирээдүйд гарч болох хүндрэлүүдийг шийдвэрлэх арга зам

Хүн ам, суурьшилтын тогтвортой байдлыг хамгаалахад томоохон уул уурхайн компаниудын хүний нөөцийн болон худалдан авах ажиллагааны бодлогод нөлөөлөл үзүүлэх, уул уурхайн бус хүрээний үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх шаардлагатай.

Өмнөговь аймгийн бичил бүсийн төвүүдэд хөгжлийн бие даасан төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Хотын хөгжлийн төлөвлөгөө нь хотын эдийн засгийн бүтцийг сайжруулах, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хот төлөвлөлтийн асуудал зэрэг олон талыг хамарсан цогц төлөвлөгөө байна.

Хот төлөвлөлтийг сайруулахын тулд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй, газар зохион байгуулалтыг ерөнхий төлөвлөгөөг уялдуулан үзэж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хотын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлүүдээс хөрөнгө оруулалтыг хийх боломжийг бүрдүүлэх, түүнийг дэмжиж ажиллах нь чухал юм.

Хотын хүн амын хэрэглээний ундны болон ахуйн цэвэр, бохир ус, дулаан, хог хаягдлын төлбөр нь тэдгээрийг, түгээх, боловсруулахад гарах зардлыг санхүүжүүлэх боломжтой бүхий зах зээлийн эдийн засгийн механизмд зохицуулагддаг шаардлагатай. Энэ нь хотын нийтийн аж ахуйг бие даан хөгжих бололцоог олгож, хот байгуулалтын суурь шугам сүлжээний ашиглалт, хамгаалалт сайжрах нөхцөл бүрдэнэ.

Хот орчмын хүрээлэн буй орчны доройтлыг нөхөн сэргээхэд зардал өндөр байдаг тул хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хогийг дахин боловсруулах, устгах нэгдсэн тогтолцоо бий болгох нь чухал юм.

Хот орчмын малтай айлууд, хот тойрсон фермерүүд нь хот байгуулалтын зориулалтаар төлөвлөгдсөн газарт ойртох, маргаан үүсэх явдал нэмэгдэх магадлалтай тул хот орчмын хамгаалалтын бүсийг тогтоох, малын бэлчээрийг зааглах хэрэгтэй.

Хотын дэд бүтэц, инженерийн байгууламжууд өргөжихийн хэрээр засвар шинэчлэлт, өргөтгөлийн ажил нэмэгдэх учир нийтийн аж ахуйн газрыг эдийн засгийн үр ашигтай ажиллуулах, цаашид бие даан үйл ажиллагааг нь тогтмол явуулах нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Орон сууц баригдах, барилгажих үйл явц нь дулааны болон ахуйн хэрэглээний усны хэрэглээг нэмэгдүүлнэ. Түүнийг хангах бололцоог бүрдүүлэхийн тулд ус үнийг чөлөөлөх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах нөхцлийг бий болгох.

Монгол Улсын хуулийн дагуу иргэн бүрт газар өмчүүлэхэд тулгуур хотуудад инженерийн байгууламжтай газрын хүрэлцээгүй байдал үүсч болох тул газар зохион байгуулалтын болон ерөнхий төлөвлөгөөг мөрдөж, газрыг дуудлага худалдаанд оруулах, газар доорхи инженерийн байгууламжийг байгуулах, газрын үнэлгээ хийлгэх зэргээр газар ашиглалтыг сайжруулах нь хомсдолоос гарах арга зам болно.

Уугуул оршин суугчдын орлогын эх үүсвэрийг хамгаалах, өсөн нэмэгдэж байгаа зардлуудыг нөхөхүйц орлогын шинэ эх үүсвэрүүдийг бий болгож байгаа үйл ажиллагааг нь дэмжиж, мэргэжлийг дээшлүүлэх, сургах, эрхлэж буй бизнесийг дэмжих зэргээр өрхийн орлогыг нь хамгаалж ажиллах хэрэгтэй.

Бүлэг III. Хүн Ам Зүй, Нийгмийн Салбарын Хөгжлийн Бодлого

Бодлогын зорилго

Хүн ам зүй, нийгмийн хөгжлийг хангах нь аймгийн иргэд, оршин суугчдын ажиллаж амьдрахад эрүүл, сурч боловсрох таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, хэт ядуурал болон ажилгүйдлийг бууруулан, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах хэтийн удирдлагыг орон нутгийн түвшинд бий болгох явдал юм.

3.1. Хүн амын өсөлтийг түргэтгэх, хүний хөгжлийг хангахад чиглэсэн стратегийн зорилтууд

Зорилт-3.1.1: Аймгийн хэмжээнд хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1.1.1. Хүн амын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх, тогтвортой харилцааг дэмжсэн бодлогын эрх зүйн орчинг бүрдүүлнэ;
- 3.1.1.2. Гэр бүлийг хөгжүүлэхэд энэ чиглэлээр ажиллаж буй ТББ, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ;
- 3.1.1.3. Уул уурхайн салбарт ажиллахаар шилжин ирэгсэдийг гэр бүлээрээ ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
- 3.1.1.4. Бүсийн хэмжээнд ажиллаж буй компаниудтай хамтран ажиллаж, иргэдийг ажилд авахдаа хүйсийн хувьд ялгавралахгүй байх бодлогыг хэрэгжүүлэх;
- 3.1.1.5. Их дээд сургууль төгссөн залуу боловсон хүчнийг орон нутагт сууришихад ажлын байраар хангах гэрээ байгуулах замаар гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлана.

Зорилт-3.1.2: Хүнийг бүх талаар хөгжүүлэхэд чиглэсэн орчинг бүрдүүлж, ахуйн таатай нөхцлийг ханган, Өмнөговь аймгийн хүний хөгжлийн түвшинг тууштай нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1.2.1. Нийгэмд амьдрах таатай орчин бүрдүүлэх замаар аймгийн хүн амын дундаж наслалтыг улсын дундажаас нэмэгдүүлнэ;
- 3.1.2.2. Соёл боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, бүсийн тулгуур төвүүдэд мэдээллийн төв, номын сан, музейн үйл ажиллагааг тогтворжуулна;
- 3.1.2.3. Мэдээллийг хурдан шуурхай авах олон арга замуудыг нэвтрүүлж, иргэдийг цаг үетэйгээ зэрэгцэн амьдрахад дэмжлэг үзүүлнэ;
- 3.1.2.4. Ханбогд суманд хувийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн телевиз байгуулна;
- 3.1.2.5. Цогтцэций суманд орон нутгийн мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд чиглэгдсэн радио станц шинээр байгуулна;
- 3.1.2.6. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачлагыг дэмжинэ;
- 3.1.2.7. Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдад спорт заал байгуулна;
- 3.1.2.8. Ханбогд, Гурвантэс, Цогтцэций сумдад тус бүр 320 хүнээс дээш суудалтай урлаг соёлын төв байгуулна;
- 3.1.2.9. Даланзадгад суманд 1500 хүний суудалтай спорт цогцолбор барина;
- 3.1.2.10. Даланзадгад суманд 500 хүний суудалтай театр барина;
- 3.1.2.11. Спортын нэгдсэн арга хэмжээг өргөн хүрээнд явуулж, бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого баримтална;
- 3.1.2.12. Даланзадгад, Цогтцэций, Ханбогд болон Гурвантэс сумдад ахуйн үйчилгээний төв барьж байгуулна.

Зорилт-3.1.3:Хүн амын механик өсөлтийг тогтворжуулж, ердийн цэвэр өсөлтийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1.3.1.Төрөлтийг дэмжиж, нас баралтыг бууруулах замаар хүн амын ердийн цэвэр өсөлтийг нэмэгдүүлэн Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийг 4 хувьд хүргэнэ;
- 3.1.3.2.Үр хөндөлтийн эрсдэлийн талаар мэдээллийг олон нийтэд хүргэж, сургалт сурталчилгааг явуулна;
- 3.1.3.3.Бүртгэлийн байгууллагуудын байрны асуудлыг шийдэж, бүртгэлийн бичиг баримтуудыг шаардлага хангасан архивт хадгална;
- 3.1.3.4.Өрх бүрийг ургийн бичиг хөтлүүлэхэд чиглэсэн олон нийтийн кампанит ажил явуулна.

3.2.Хэрэглээний бүтцийг сайжруулах стратегийн зорилтууд

Зорилт-3.2.1:Аймгийн хэмжээнд хүн амын хүнсний хангамжийг сайжруулж, хүнсний хэрэглээний төрөл зүйлийг олшруулна

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.1.1.Хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг 2008 оны түвшингээс 30 хувь, сүү сүүн бүтээгдэхүүний хангамжийг 20 хувиар өсгөнө;
- 3.2.1.2.Хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэглээг бий болгоход хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн эдийн засгийн хөшүүргийг боловсруулж хэрэгжүүлнэ;
- 3.2.1.3.Хүнсний хэрэглээний олон хэлбэр ба тэдгээрийн үр ашигтай талыг харуулсан олон нийтийн кампанит ажил явуулах замаар зах зээлийг өргөжүүлж, хувийн хэвшлийнхэнд өрсөлдөх боломж үүсгэнэ;
- 3.2.1.4.Хүнсний ногоо болон бусад хэрэглээний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд чиглэсэн эрчимжсэн аж ахуйг бодлогоор дэмжинэ.

Зорилт-3.2.2:Хүнсний бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.2.1.Бичил бүсүүдийн тулгуур төвүүдийг төвийн эрчим хүчинд холбох ажлын хэрэгжилтийг эрчимжүүлж, тулгуур төвүүдийг 24 цагийн туршид цахилгаанаар хангаснаар хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хадгалалтын чанарыг сайжруулна;
- 3.2.2.2.Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн он, сар, өдрийг хэрэглэгчдэд тодорхой байлгах үүднээс аливаа бүтээгдэхүүний хаяг шошгийн стандартыг чандлан мөрдүүлнэ;
- 3.2.2.3.Хор судлалын шинжилгээг бүрэн хийхэд шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмжөөр Стандарт хэмжилзүйн харьяа лабораторийг хангаж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ;
- 3.2.2.4.Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн стандартыг салбарын аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлж, энэ дагуу төрөлжсөн сургалт зохион байгуулна;
- 3.2.2.5.Чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн худалдаалж байгаа болон эрүүл ахуйн шаардлага хангахгүй аж ахуйн нэгжийг олон нийтэд мэдэгдэнэ;
- 3.2.2.6.Байнгын ажиллагаатай хоёр боомтод хүнсний ногоо болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд шавьж устгах бордоо, хүний биед хортой химийн бодис болон нянг судлах тасаг байгуулж, Даланзадгад суманд байрлаж буй лабораторитой нягт уялдаатай ажлуулна.

Зорилт-3.2.3:Аймгийн хүнсний хангамжийг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, хэрэглээний зохистой бүтцийг бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2.3.1.Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд хувийн хэвшилд дэмжлэг үзүүлнэ;

3.2.3.2.Үйлдвэрлэлийн болон хэрэглээний явцад гарах хог хаягдлыг төрөлжүүлэн ангилж, дахин ашиглах менежментийг нэвтрүүлнэ.

Зорилт-3.2.4:Ундны усны чанарыг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.2.4.1.Усыг зохистой ашиглах, бохир ус цэвэрлэгээний түвшинг сайжруулахад чиглэсэн эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна;

3.2.4.2.Ундны усны чанарыг шалгах хэлтсийг Даланзадгад дахь хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний төвд байгуулна;

3.2.4.3.Сумын төвүүд болон бичил бүсийн төвүүдийн ундны усны чанарыг шинжилж, Өмнөговь аймгийн усны нэгдсэн мэдээллийн сан байгуулна;

3.2.4.4.“Цэвэр ус – Эрүүл хүн” хөтөлбөр хэрэгжүүлж хэт хатуулаг ихтэй буюу хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх усны нөөцтэй төв суурин газруудыг тогтоож, эдгээр төв суурин газруудын нийтийн усан хангамжинд зохих технологийг нэвтрүүлэх замаар усны чанарыг сайжруулна;

3.2.4.5.“Цэвэр ус – Эрүүл хүн” хөтөлбөрийн хүрээнд усны чанарын ерөнхий зураглалыг аймгийн хэмжээнд гаргаж төв суурин газраас алслагдмал амьдрах малчдын ундны усны чанарыг сайжруулах зөөврийн төхөөрөмжөөр хангана;

3.2.4.6.Уул уурхайн бүстэй ойр газруудад усны шинжилгээг 2 жил тутамд явуулж, ундны усны чанарт өөрчлөлт орж байгаа эсэхийг шинжилнэ;

3.3.Ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах стратегийн зорилтууд

Зорилт-3.3.1:Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулж, нийгмийн хамгааллыг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.3.1.1.Бүсийн хөгжлийн давуу тал нөөц боломжийг бүрэн ашиглаж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлыг байрыг бий болгоно;

3.3.1.2.Эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх замаар ядуурлыг эрс бууруулна;

3.3.1.3.Уул уурхай дагасан бизнесийг орон нутагт хөгжүүлэхэд хувийн хэвшлийг зохистой бодлогоор дэмжинэ;

3.3.1.4.“Хувь хүнийг чадваржуулах” хөтөлбөр хэрэгжүүлж, ажилгүй хүмүүсийг хэрэгцээт ажлын байранд дадлага хийлгэх замаар ирээдүйн чадварлаг боловсон хүчинг бэлтгэн, ажилгүйдлийг бууруулна;

3.3.1.5.Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор өрхийн гар урлалыг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

Зорилт-3.3.2:Ядуу, нэн ядуу бүлэгт хамрагдах өрхийн тоог 2008 оны түвшинтэй харьцуулахад 25 хувиар бууруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.3.2.1.Зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжил эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулж, эдгээр сургалтуудад ядуу, нэн ядуу өрхүүдийг түлхүү хамруулна;
- 3.3.2.2.Суурь боловсролыг нөхөн эзэмшүүлэх замаар иргэдийг чадваржуулна;
- 3.3.2.3.Нийгмийн халамжийн тэтгэмж олгох шалгуурыг сайжруулж, халамж хүртэгсдийг илүү оновчтой тодорхойлох замаар зорилтот хэсэгт хүргэнэ;
- 3.3.2.4.Ажилд жуулчлах үйлчилгээг эрчимжүүлж, ажилгүйчүүдийг бүртгэх бүртгэлийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд боловсруулна;
- 3.3.2.5.Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зорилгоор “Өрхийг Чадавхижуулах” хөтөлбөр хэрэгжүүлж, банк болон санхүүгийн байгууллагаар дамжуулан хөнгөлттэй бичил зээлийг олгоно;
- 3.3.2.6.Аймгийн хэмжээнд буй нэн ядуу өрхүүдэд зориулан, өрхийн амьжиргааг дээшлүүлэх бизнес сургалтыг ТББ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна;
- 3.3.2.7.Ажилд жуулчлах төвд тулгуурлан бүх сумдын болон бичил бүсийн тулгуур төвүүдийн нийгмийн халамжийн хэлтэсийг уг системтэй холбон, улмаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, уул уурхайн компаниуд болон бусад байгууллагуудтай ойр ажиллаж, энэхүү системд бүртгэлтэй иргэдийг ажлын байранд жуулчилна;
- 3.3.2.8.“Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг эрчимжүүлж, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулна;
- 3.3.2.9.Ахмад настан малчдын эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудлыг шийдэх хөрөнгө бүрдүүлж шийдвэрлэнэ.

3.4.Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх стратегийн зорилтууд

Зорилт-3.4.1:Цэцэрлэг болон ерөнхий боловсролын байгууллагын орчинг сайжруулж, сургалтын чанарыг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.4.1.1. Даланзадгад суманд тус бүр нь 150 хүүхдийн ортой гурван цэцэрлэг байгуулна;
- 3.4.1.2. Ханбогд суманд тус бүр нь 150 хүүхдийн ортой хоёр цэцэрлэг, тус бүр нь 640 хүүхдийн суудалтай хоёр бүрэн дунд сургуультай хамт барьж, цэцэрлэг-сургууль цогцолбор байгуулна;
- 3.4.1.3.Гурвантэс, Цогтцэций сумдад тус бүр нь 150 хүүхдийн ортой хоёр цэцэрлэгийг шинээр барина;
- 3.4.1.4.Сэврэй суманд шинээр 95 хүүхдийн ортой цэцэрлэг барина;
- 3.4.1.5.Даланзадгад суманд 640 хүүхдийн суудалтай хоёр бүрэн дунд сургууль шинээр байгуулна;
- 3.4.1.6.Цогтцэций суманд 320 хүүхдийн суудалтай хоёр бүрэн дунд сургууль шинээр байгуулна;
- 3.4.1.7.Гурвантэс суманд 640 хүүхдийн суудалтай бүрэн дунд сургууль шинээр байгуулна;
- 3.4.1.8.Даланзадгад, Ханбогд сумдад 150 хүүхдийн ортой хоёр дотуур байр шинээр барина;
- 3.4.1.9.Цогтцэций суманд 100 хүүхдийн ортой дотуур байр шинээр барина;
- 3.4.1.10.Цогтцэций сумын ерөнхий боловсролын сургуулийг өртгөтгөж, бүрэн дунд боловсролыг олгох боломжийг бүрдүүлнэ;
- 3.4.1.11.Гурвантэс суманд 150 хүүхдийн ортой дотуур байр шинээр барина;
- 3.4.1.12.Цэцэрлэгийн хувилбарт сургалтыг орон нутагт бодлогоор дэмжиж, үйл ажиллагааг өргөтгөх чиглэлээр хувийн хэвшилийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана;

- 3.4.1.13.Бага, дунд болон бүрэн дунд сургуулиудад стандарт шаардлага хангасан төрөлжсөн анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлж, сурах орчинг сайжруулна;
- 3.4.1.14.Сургуулийн байгууламжийн гаднах орчинг сурагчдад байгаль экологийн боловсрол болон бүтээлч сэтгэлгээ, хайрлан хамгаалах үзэл санааг төрүүлэх чиглэлээр тохижуулна;
- 3.4.1.15.Төрөлжсөн гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиудыг санхүүгийн болон бусад арга хэрэгслээр урамшуулах, хувийн хэвшлийн сургууль байгуулахыг онцгой анхаарч дэмжинэ;
- 3.4.1.16.Хувийн сургуулиуд байгуулахад тааламжтай нөхцөлийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ;
- 3.4.1.17.Сургуулийн багш нарыг гэрээний үндсэн дээр сургаж, боловсролын чанарыг дээшлүүлнэ;
- 3.4.1.18.Даланзадгад, Ханбогд, Гурвантэс, Цогтцэций сумдад “Хүүхдийн ордон” барьж сурагчдийн хичээлээс гадуурхи дугуйлан секцид хамрагдах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ;
- 3.4.1.19.Бичил бүсийн тулгуур сумдаас бусад сумдад хүүхэд хөгжлийн төвийг ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна;
- 3.4.1.20. Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын засвар шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;
- 3.4.1.21.“Нэг хүүхдэд нэг компьютер” хөтөлбөрт аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдийг хамруулна;
- 3.4.1.22.Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг нэмэгдүүлнэ;
- 3.4.1.23. Сургуулийн номын сангуудад англи хэлний сургалтын иж бүрэн кабинет байгуулна.

Зорилт-3.4.2:Боловсролын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэн, соёл урлагийн байгууллагуудыг орчин үеийн стандартад нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.4.2.1.Сурган хүмүүжүүлэх багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна;
- 3.4.2.2.Багшлах боловсон хүчний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин ирж байгаа мэргэжлийн багш нарыг урамшуулах бодлого баримтлана;
- 3.4.2.3.Сумын төвийн болон бичил бүсийн соёл урлагийн салбарын шинэчлэлийг өргөн хүрээнд хэрэгжүүлнэ;
- 3.4.2.4.Даланзадгад суманд аймгийн төв номын сангийн байр барина;
- 3.4.2.5.Шинэ баригдах номын санг тохижуулж, номын сангийн фондыг өргөтгөн, англи хэлний сургалтын иж бүрэн загвар кабинет байгуулна;
- 3.4.2.6.Багшлах боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн сурах эрмэлзэлийг дээшлүүлэх замаар өрсөлдөх чадвар бүхий төгсөгчдийг бэлтгэнэ.

Зорилт-3.4.3:Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төвүүдийн сургалтын орчныг сайжруулан өргөтгөж, чухал шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэн нийлүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.4.3.1.ШУТИС-н харьяа уул уурхайн чиглэлийн салбар сургуулийг Даланзадгадад байгуулна;
- 3.4.3.2.МСҮТ-үүдийн багшлах боловсон хүчинг гадаадын улс орнуудад мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтанд үе шаттайаар хамруулна;
- 3.4.3.3.Мэргэжлийн боловсролын стандарт, үнэлгээний системийг боловсронгуй болгон шинэчилнэ;
- 3.4.3.4.МСҮТ-үүдийн материаллаг баазыг бэхжүүлнэ;

3.4.3.5. Даланзадгад суманд уул уурхайн дагалдах үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх МСҮТ-ийг байгуулна;

3.4.3.6.МСҮТ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэхэд боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжиж буй төсөлтэй хамтран ажиллана;

3.4.3.7.Даланзадгад сумын МСҮТ-ийг Монголын Говийн бүсийн уул уурхайн бүрэн бус дунд мэргэжилтэй ажилчид бэлтгэх төв болгоход чиглэсэн бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн стратегийн зорилтууд

Зорилт-3.5.1:Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээг түргэн шуурхай найдвартай болгож, үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй, эрүүл мэндийг дэмжсэн орчинг бий болгох ажлыг эрчимжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.5.1.1.Монголын Говийн бүсийн эмчилгээний оношилгооны төвийг Даланзадгад суманд байгуулах ажлыг бүх талаар дэмжинэ. Шаардлагатай зураг төсөл боловсруулах болон бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ;

3.5.1.2.Даланзадгад дахь аймгийн нэгдсэн эмнэлгийг өргөтгөж, Говийн бүсийн эмчилгээний оношилгооны төвийг байгуулахад шаардлагатай барилга байгууламжийг барина;

3.5.1.3.Бүсийн эмчилгээ оношилгооны төвд алсын зайн оношилгоог нэвтрүүлж, цахим оношилгооны чадавхийг нэмэгдүүлж, бичил бүсийн нэгдсэн эмнэлгүүдтэй холбоно;

3.5.1.4. Даланзадгад хотын нэгдсэн эмнэлгийн оношлогоо эмчилгээний чанар үр дүнг сайжруулах зорилгоор хавдарын бус өвчлөлтийг эрт илрүүлэхэд шаардлагатай аппарат тоног төхөөрөмжөөр хангах, ялангуяа зөөврийн рентген аппарат гэх мэт хөдөлгөөнт оношилгоонд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана;

3.5.1.5. Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдын эмнэлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, бичил бүсийн нэгдсэн эмнэлэг болгоход шаардлагатай барилга орон сууцыг барина;

3.5.1.6. Бичил бүсийн нэгдсэн эмнэлгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, чадвахийг сайжруулна;

3.5.1.7. Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумдад орших эмнэлэгийн шинжилгээний лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана;

3.5.1.8.Аймаг болон сумдын эмнэлэгүүдийн цахилгаан, дулаан, усан хангамжийг сайжруулж, засварыг чанарын өндөр түвшинд үе шаттайгаар гүйцэтгэх ажлыг эрчимжүүлж, түргэн тусламжийн автомашины эдэлгээнд судалгаа хийн парк шинэчлэлийг үе шаттайгаар шийдвэрлэнэ;

3.5.1.9.Аймагт нэг хүнд ноогдох эмнэлэгийн зардалыг тооцож өрхийн болон сумын эмнэлгүүдийг санхүүжүүлдэг механизмыг бүрэн нэвтрүүлнэ;

3.5.1.10.Аймгийн бүх түвшний эмнэлэгүүдийг магадлан итгэмжлэлд бүрэн хамруулна;

3.5.1.11.Сумдын эмнэлэгүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангахад анхаарч, ажиллана;

3.5.1.12. Гурвантэс, Даланзадгад ба Ханбогд сумдад ахмадын амралт сувилалын газрыг байгуулна;

3.5.1.13.Ахмадын амралт сувилалын газрыг түшиглэн хүүхдийн хоол тэжээлийн төвийг байгуулна.

Зорилт-3.5.2: Аймгийн эрүүл мэндийн удирдлагын болон нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэн, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн идэвхитэй оролцоог хангах замаар хамтын ажиллагааг өрнүүлж, эрүүл мэндийг дэмжсэн орчинг бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.5.2.1. Даланзадгад суманд эрүүл мэндийг дэмжих төв байгуулан, сум бүрт нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор чийрэгжүүлэлтийн төвийг сургалт мэдээллийн төвтэй хоршин байгуулна;
- 3.5.2.2. Чийрэгжүүлэлтийн төвд тулгуурлан ард иргэдийн дунд эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эерэг хандлага бий болгох чиглэлээр кампанит ажил өрнүүлж, олон нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлнэ;
- 3.5.2.3. Эрүүл мэндийн үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжилтийг эрчимжүүлж, эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг эрчимжүүлэн, орчны эрүүл мэндийг сайжруулах ажлын хүрээнд олон талт ажлыг зохион байгуулна;
- 3.5.2.4. ДОХ болон бэлгийн замын халдварт өвчний хяналт, тандалтыг сайжруулна;
- 3.5.2.5. Сайн дураар зөвлөгөө авч, эмчийн хяналтанд байх аргыг нийтийн хүртээл болгон хэвшүүлнэ;
- 3.5.2.6. Эрүүл мэндийн удирдлагын чадавхийг сайжруулж, эмч мэргэжилтэнгүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлнэ;
- 3.5.2.7. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын гадаад харилцааг өргөжүүлнэ;
- 3.5.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангахад анхаарч, бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл бололцоог бүрдүүлнэ;
- 3.5.2.9. “Амны хөндийн эрүүл мэнд” хөтөлбөрийг бага ангийн хүүхдүүдийн дунд хэрэгжүүлнэ;

3.6. Хүн амын нутагшилт, соёлын өв хадгалахад чиглэсэн стратегийн зорилтууд

Зорилт-3.6.1: Өмнөговь аймгийн хэмжээнд соёлын өв уламжлалыг хадгалж хамгаалах, судлаж сурталчилах, өвлүүлэн уламжлуулах говийн экосистем, уламжлал зан заншлийг хойч үед таниулахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.6.1.1. Аймгийн музейг өргөтгөх зорилгоор зориулалтын барилгыг шинээр барина;
- 3.6.1.2. Оюу Толгойн орд газрын олдворууд, чулуун олдворуудад тулгуурлаж Ханбогд суманд уул уурхайн музей байгуулна;
- 3.6.1.3. Сургууль, цэцэрлэгүүдэд “Монгол ёс заншил” зан үйлийн танхим байгуулна;
- 3.6.1.4. Өмнөговь аймгийн хэмжээнд говийн экосистем, уламжлал зан заншлийг хойч үед таниулахад чиглэгдсэн сургалтын хөтөлбөрөөр агуулгыг баяжуулна;
- 3.6.1.5. Өмнөговь аймгийн мэдээлэл, харилцаа холбооны өнөөгийн сүлжээг сайжруулж хүн амын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангана;
- 3.6.1.6. Уламжлал, зан заншил байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлүүдээр сургалтын агуулгыг баяжуулна;
- 3.6.1.7. Соёлын өвийн хадгалалт хамгаалалт, уламжлалт зан заншил, уламжуулан өвлүүлэх байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын агуулгыг баяжуулж, уламжлалт ёс заншлийн өргөөг байгуулна.

3.7.Нийгмийн дэг журмыг хангахад чиглэсэн стратегийн зорилтууд

Зорилт-3.7.1:Гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн дэг журмыг бэхжүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар оршин амьдрах аюулгүй орчинг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.7.1.1.Аймгийн хэмжээнд цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, бичил бүсийн тулгуур төвүүдэд байрлах цагдаагийн байгууллагын бүрэлдэхүүнийг нэмэгдүүлнэ;

3.7.1.2.Хууль хяналтын байгууллагын албан хаагчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтанд суулгах, зохих арга хэмжээг авна;

3.7.1.3.Иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг сайжруулан, “Эрх зүйн туслалцаа үзүүлэх” төвүүдийг бичил бүсүүдэд байгуулж, гэмт хэрэг, архидалт, түүнийг бий болгож буй хүчин зүйлсэд нөлөөлөх замаар иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ;

3.7.1.4.Өмнөговь аймгийн мэргэжлийн хяналтын газрын бүтцийг тэлж, орон тоог нэмэгдүүлнэ;

3.7.1.5.Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаална;

3.7.1.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шүүхийн шийдвэр, тогтоолыг биелүүлэх, иргэд байгууллагын зөрчигдсөн эрх ашгийг сэргээх, хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг хангаж ажиллана.

Зорилт-3.7.2:Гамшигийн менежментийг боловсронгуй болгон, онцгой байдлын үед авах арга хэмжээг сайжруулж, аюулаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.7.2.1.Гал, үерийн аюул, газар хөдлөлт зэрэг байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, менежментийг нь эрс сайжруулна;

3.7.2.2.Даланзадгадад нэгдүгээр зэрэглэлийн аврах гал унтраах анги болгон хүчин чадлыг нэмэгдүүлнэ;

3.7.2.3.Цогтцэций болон Ханбогд суманд хоёрдугаар зэрэглэлийн аврах гал унтраах анги байгуулж, зохих техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, зэвсэглэмжийг бүрдүүлнэ;

3.7.2.4.Гурвантэс суманд гуравдугаар зэрэглэлийн аврах гал унтраах анги байгуулж, зохих техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, зэвсэглэмжийг бүрдүүлнэ;

3.7.2.5.Химийн хорт болон цацраг идэвхт бодис алдагдах, хүн, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин гарахад авах арга хэмжээг оновчтой боловсруулна;

3.7.2.6.Аймгийн онцгой байдлын газарын боловсон хүчнийг сургалтанд хамруулж ажилчдын нийгмийн хамгааллыг сайжруулна.

Бүлэг IV. Эдийн Засгийн Салбарын Хөгжлийн Бодлого

Бодлогын зорилго

2009-2015 онд уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн үндэс суурийг тавьж, 2016-2021 онд уул уурхайгаас хараат бус үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх чиглэлд анхаарах, цаашлаад гадаад худалдааны бүс нутаг болон хөгжих бэлтгэлийг хангаж эхлэх, экспортын баримжаатай, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгох. Аймгийг бичил бүсүүдэд хуваан хөгжүүлэх, эдийн засгийн үүргийг тодорхойлох.

4.1.Макро эдийн засгийн стратегийн зорилтууд

Зорилт-4.1.1:Өмнөговь аймгийн зүгээс нэгдсэн байдлаар худалдаа хийх систем бүрдүүлэх, жижиглэн үйлдвэрлэгчдийг биржийн тогтолцоонд холбож өгөх, тус биржийг аймгийн оролцоотой орон нутгийн компани хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг эхлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.1.1.МАН-н түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах зориулалт бүхий үйлдвэрлэлүүдийг байгуулан, уул уурхайд түшиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндэс суурийг тавих;

4.1.1.2.Аялал жуулчлалын зорих газруудын үнэлгээг хийх, одоогийн байгаа жуулчны баазууд болон зорих газрын таталцалын үнэлгээг хийх, жуулчны бааз байгуулагдаагүй байгаа зорих газруудыг хамгаалалтад авах, эдийн засгийн үнэлгээг хийж, үйл ажиллагааг өргөтгөх;

4.1.1.3.Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих боломж бүрдүүлэх, гадаад дотоод худалдааг дэмжих дэд бүтцийг бий болгох;

4.1.1.4.Гашуун сухайтын боомтын нэвтрүүлэн өнгөрүүлэх үйлчилгээний чанар, нөхцөлийг сайжруулах, бараа эргэлт, жуулчлалын нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

4.1.1.5.Орон нутгийн төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох;

4.1.1.6.Говийн бүсийн банк, санхүүгийн тогтолцоог бий болгоход чиглэн Дорноговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын удирдлагуудтай харилцан ойлголцож нэгдсэн баримт бичиг боловсруулан засгийн газарт өргөн барих;

4.1.1.7.Аймгийн хөгжлийг түргэтгэх, уул уурхайн баялагаас орон нутагт өгөх өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Өмнөговийн Хөгжлийн Санг байгуулах;

4.1.1.8.Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн менежмент, мэдээллийн технологийг тууштай нэвтрүүлэх;

4.1.1.9.Газрын үнэлгээний асуудлыг шинэ сууршлын бүсүүдэд эхнээс нь цэгцтэйгээр авч үзэх. Баригдсан үл хөдлөх хөрөнгийг капиталын түвшинд буюу санхүүгийн аль ч чиглэлийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдөж барьцаа хөрөнгө болдог системийг бүрдүүлэх. Ингэж хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэх боломжийг жижиг компаниуд цаашлаад хувь хүмүүст олгох;

Зорилт-4.1.2:Бизнесийн орчныг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.2.1.Нэгдсэн зохион байгуулалттай Нийгмийн Хариуцлагын Түншлэлийн Бүтэцийг бий болгох замаар үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, чиглэлүүдийг оновчтой тодорхойлж, нийгмийн асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх;

4.1.2.2. Нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагууд болон уул уурхайн компаниудын хамтын ажиллагааг Түншлэлийн хүрээнд өргөжүүлэн, үр өгөөжийг бодитой болгох.

Зорилт-4.1.3: Уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагаанд нөлөөлөх боломжийг судлан сайжруулах, орон нутгийн гаралтай бүтээгдэхүүнд давуу тал олгох нөхцлийг тусгуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.3.1. Аймгийн хэмжээнд бизнес эрхлэлтийг дэмжих, ялангуяа эмэгтэйчүүдийн ажлын байр шингээлт ихтэй салбаруудад онцгой анхаарах;

4.1.3.2. Хөнгөн хүнсний үйлдвэрлэл хөгжүүлэх суурь нөхцлийг бүрдүүлэхийн тулд олон улсын стандартад нийцсэн хяналтын лаборатори байгуулах.

Зорилт-4.1.4: Макро эдийн засагт дунд хугацааны тогтвортой өсөлтийг бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.4.1. Уул уурхайд түшиглсэн, технологи шингээлт өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх, эдийн засгийн бодит секторуудад өсөлт бий болгох;

4.1.4.2. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бэлтгэл хангалтад мониторинг хийж, дүгнэлтүүдийг үнэлэн үзэж, хөгжлийн хөтөлбөрт холбогдох өөрчлөлтийг оруулах.

4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого

Зорилт-4.2.1: Боловсруулах аж үйлдвэрийн салбарыг жилд дунджаар 40 хувиар өсгөх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.2.1.1. Олон улсын байгууллагууд, банк санхүүгийн байгууллагуудтай хамтран зээлдэгч буюу үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй оролцогчдыг илрүүлэн менежментийн сургалт, зөвлөгөөг үе шаттайгаар өгөх;

4.2.1.2. Боловсруулах үйлдвэр байгуулах газруудыг тодорхой болгон сумдын ерөнхий төлөвлөгөөнд суулгаж өгөх;

4.2.1.3. Цахилгаан эрчим хүч, усны хангамж зэрэг дэд бүтцийг бий болгох;

4.2.1.4. Даланзадгад хотод барилгын материалын болон малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах;

4.2.1.5. Өндөр технологи нутагшуулах, технологийн судалгаа, туршилтын төвийг байгуулан ажиллуулах;

4.2.1.6. Бүсүүдэд болон сумдад нөөц боломж, хэрэгцээнд тулгуурлан талх нарийн боов, гутал, эсгий, махан бүрээгдэхүүн, сүү цагаан идээний болон төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл бий болгох;

4.2.1.7. Даланзадгад суманд түүхий эд, бүтээгдэхүүний бирж /төвлөрсөн зах/ байгуулах;

4.2.1.8. Сумдад худалдаа, үйлчилгээний бөөний сүлжээний цэг салбарыг нээж ажиллуулах, биржийн бараа таталын тогтолцоог бий болгох.

Зорилт-4.2.2: Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.2.2.1. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжд нутгийн захиргааны байгууллагаас олгодог зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох ажлыг түргэн шуурхай болгож, нэг цэгийн үйлчилгээний нэгжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх.

4.2.2.2. Бизнес мэдээллээр хангах, техник технологийн сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагуудын салбар, хэлтэс, зөвлөх үйлчилгээний компаниудыг үйл ажиллагаагаа явуулахыг бодлогоор дэмжих;

4.2.2.3. Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих, бизнес инкубаторуудыг бүсүүдийн төв бүрт байгуулан ажиллуулах;

4.2.2.4. Бүсийн тулгуур төвүүдэд Үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулан ажиллуулах.

Зорилт-4.2.3: Экспортод баримжаалсан боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.2.3.1. Үйлдвэрлэл технологийн паркуудыг өргөжүүлэн хөгжүүлэх;

4.2.3.2. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих институтыг байгуулан ажиллуулах. Тухайн байгууллагын үндсэн чиг үүрэг нь бичил бүсийн бусад бүсүүдтэй харилцах эдийн засгийн харилцааны тэнцэлийг хангах;

4.2.3.3. Нэгдсэн зөвлөлөөсөө жил бүрийн эдийн засгийн шийдвэрлэх асуудлууд, арга зүйг боловсруулах ИТХ-д хүргүүлж байх.

4.3. Уул уурхай, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн стратегийн зорилтууд

Зорилт-4.3.1: Өмнөговь аймагт уул уурхай, хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагчид, компани аж ахуйн нэгжийн оролцоог хангах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.3.1.1. Хайгуулын лиценз бүхий талбайн хайгуулын ажлуудыг эрчимжүүлэх талаар лиценз эзэмшигчидтэй уулзалтууд зохион байгуулах, байгалийн баялагийн ашиглалтын талаарх аймгийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, жил бүр шинэчлэлт хийж байх;

4.3.1.2. Ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулахад бодлогоор дэмжих;

4.3.1.3. Уул уурхайн компаниудын хайгуул буюу олборлолтын үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, орон нутгийг удирдлагад нь хүлээлгэн өгсөн байдалд тавих хяналтыг сайжруулж, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтэнд жил бүр үнэлэлт дүгнэлт өгч ажиллах;

4.3.1.4. Уурхайгаас худалдааны болон татан авалтын зориулалтаар авто болон төмөр замаар тээвэрлэлтийг хийж байгаа тохиолдолд тээвэрлэлтийн хэмжээнээс үл хамааран нэгдсэн стандартыг мөрдүүлж ажиллах;

4.3.1.5. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд ТХХТ зарчимд тулгуурлан дунд хугацааны дэд төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх;

Зорилт-4.3.2: Боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн бодлогын болон цаг хугацааны шийдвэрүүдэд мониторинг хийх, цаашдын чиг хандлага хөгжлийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.3.2.1. Уул уурхайн олборлолтын томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчийг эрдэс баялаг, түүхий эдийн нөөцийг иж бүрэн хаягдалгүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологийг нэвтрүүлж ажиллахыг бодлогоор дэмжих;

4.3.2.2. Эрдэс баялаг, түүхий эдийн боловсруулалтын түвшинд ажиллах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар бодлогын түвшинд дэмжих;

4.3.2.3. Өмнөговь аймгийн нутгийн захиргааны зүгээс чухал шаардлагатай мэргэжлийн инженер техникийн боловсон хүчнийг гадаадын их дээд сургуульд суралцуулахад дэмжлэг үзүүлэх.

4.4. Хөдөө аж ахуйн хөгжлийн стратегийн зорилт

Зорилт-4.4.1: Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.4.1.1. Малын үүлдэр угсааны чанарыг сайжруулах, нутгийн болон нутагшуулсан омогуудын үржил селекцийг үе шаттайгаар хийх;

4.4.1.2. Өмнөговь аймгийн МАА-г эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

4.4.1.3. Аймгийн бэлчээрийн даацад тулгуурлан мал сүргийн бүтцийг зохистой хэмжээнд байлгах, говийн сүргийн бүтцийг тооцон бичил бүсүүд дэх малын тоо толгойг бодлогоор тогтоох;

4.4.1.4. Малын үржлийн биологийн лаборатори байгуулан ажиллуулах;

4.4.1.5. Газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн фермерийн загвар аж ахуй байгуулах санаачилгыг бүх талаар дэмжих;

4.4.1.6. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг боловсронгуй болгож, материалаг бааз, боловсон хүчний хангамжийг нь сайжруулан Өмнөговь аймгийг “Эрүүл малын бүс” болгох;

4.4.1.7. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг худаг, уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд оновчтой хэлбэрээр эзэмшүүлэх;

4.4.1.8. Бэлчээрийн байдал, усан хангамжийн хүрэлцээний судалгаа, үзлэгийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үнэлгээ дүгнэлт гаргуулан бэлчээрийг зохистой ашиглах;

4.4.1.9. Малчдыг малын ашиг шимийг дээшлүүлж байгаа ажлын арга туршлагаа солилцох, суралцах, өндөр ашиг шимт малаа солилцох, үржлийн шилмэл малаа сурталчилах зэрэг арга хэмжээнд хамруулах.

Зорилт-4.4.2: Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай газар тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.4.2.1. Аймгийн газар тариалагийн үйл ажиллагааг нэгдсэн бодлого, хөтөлбөрөөр хангах “Атрын III аян”, аймгийн “Ногоон хувьсгал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

4.4.2.2. Тариалан эрхэлж буй иргэдэд үрийн бодлого, усалгааны систем, борлуулалтыг аймгийн түүхий эд, бүтээгдэхүүний нэгдсэн биржээр дамжуулан дэмжлэг үзүүлэх;

4.4.2.3. Мэргэжилтэй тракторч, фермерүүд, ногоочид, бэлтгэхийг бодлоогоор дэмжих. МСҮТ-д газар тариалангийн мэргэжлийн ангиудыг нээх.

4.4.2.4. Усалгаатай газар тариаланд орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, техник тоног төхөөрөмжийг лизингээр олгох тогтолцоог бүрдүүлж, нэг центр тутмаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх;

4.4.2.5. Хөдөө аж ахуйн салбарыг **хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор** болгон хөгжүүлэх судалгааны ажлыг бичил бүс бүрт хийх, үнэлгээг ИТХ-аар хэлэлцүүлэн шаардлагатай тохиолдолд бодлогын баримт бичигийг боловсруулах.

4.5. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого

Зорилт-4.5.1: Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 15 хувьд хүргэж аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.5.1.1. Төвийн бүсд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийг бодлогоор хязгаарлаж аялал жуулчлалыг онцгойлон хөгжүүлэх бүс болгох;

4.5.1.2. Зорих газруудын үнэлгээг байгалийн бүс бүслүүрийн онцлог, экосистемийн нөхцөл, нийгэм соёлын байдлыг харгалзан тус бүрд нь бүсчлэл тогтоон хамгаалалтанд авах;

4.5.1.3. Гашуун сухайт ба Шивээ хүрэнгийн боомтуудыг аялал жуулчлал, гадаад худалдааны боомт болгон хөгжүүлэх бодлогыг баримтлах; Өмнөд хөршийн аялал жуулчлалын сүлжээтэй холбогдон, дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндий, өөрийн орны бусад түүхэн болон байгалийн өвөрмөц тогтоц, аялал жуулчлалын сүлжээгээр дамжуулан ОХУ, Байгаль нуур орчмын аялал жуулчлалын бүсүүдтэй холбож, Хятад Оросын хооронд дамжин өнгөрөх олон улсын гарцыг бий болгох бодлогыг баримтлах;

4.5.1.4. Аялалын тогтоосон маршрутын дагуух авто замыг засварлаж, тэмдэгжүүлэх;

4.5.1.5. Монголын аялал жуулчлалын салбарын гол эвентүүдийн нэг тэмээний баяр, өвлийн тэмээн аялалыг тус аймгийн брэнд бүтээгдэхүүн болгон олон улсын хэмжээнд зарлаж, тэмээний музейг шинэчлэн байгуулах, жуулчдын баазууд нь орон нутгийн болон өөрийн үйл ажиллагааны онцлогийг харуулсан шинэ эвентүүдийг гарган хөгжүүлж, өргөн сурталчилах;

4.5.1.6. Тэмээний баяр, тэмээний музейг Өмнөговийн аялал жуулчлалын бүх маршрутад оруулах;

4.5.1.7. Жуулчны баазуудын үйлчилгээний үнэлгээг жил бүр хийж стандартчлалын дагуу үйл ажиллагаа явуулах;

4.5.1.8. Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг үүсгэн интернетийн орчинд тавих, линкүүдийг тур операторын компаниудын сайтад байрлуулах;

4.5.1.9. Нутгийн иргэдэд түшгэлсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, аялал жуулчлалаас орон нутагт орж байгаа орлогыг тодорхойлон, жуулчны байгууллагуудын орон нутагт оруулсан орлогыг нэгтгэн гаргадаг системд оруулах.

Зорилт-4.5.2: Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгох, менежментийг нь боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.5.2.1. Аймгийн нисэх буудал, Тэмээний музей зэрэг газруудад Өмнөговь аймгийн танил зорих газруудтай холбоотой бүхий л мэдээллээр хангадаг байх;

4.5.2.2. Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулах зорилтыг төвийн дэд бүсийн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэх;

4.5.2.3. Аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтанд үе шаттайгаар хамруулах;

4.5.2.4. Баазуудад ажиллах мэрэгжилтэй ажилчдыг бэлтгэх ажлыг МСҮТ-тэй хамтран зохион байгуулах.

Зорилт-4.5.3: Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэн аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 7.0 хувьд хүргэнэ:

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.5.3.1. Аялал жуулчлалын үйл ажиллагааг улирлаар нь ангилан улирлын маршрутууд бий болгох;
- 4.5.3.2. Орчин үеийн зочид буудал, жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулах;
- 4.5.3.3. Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах.

4.6.Зам, тээврийн хөгжлийн стратегийн зорилтууд

Зорилт-4.6.1: **Аймгийн тээврийн үйлчилгээг өргөтгөн, авто замын сүлжээг сайжруулж гол чиглэлийн замыг хатуу хучилттай болгох**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.6.1.2. Авто замын салбарыг хөгжүүлэхэд улсын ба орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлэх;
- 4.6.1.3. Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулан, замын тэмдэгжүүлэлтийг хийж мөрдүүлэх;
- 4.6.1.4. Таван толгой-Оюу толгой- Гашуун сухайт, УБ-Мандалговь-Даланзадгад, Шивээ хүрэн-Гурвантэс чиглэлүүдийн авто замыг хатуу хучилттай болгох;
- 4.6.1.5. Тавантолгой-Оюутолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг байгуулах;
- 4.6.1.6. Хот хоорондын болон орон нутгийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь тогтмол явуулах;
- 4.6.1.7. Аймгийн нисэх буудлыг өргөтгөж, олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх.

Зорилт-4.6.2: **Авто болон төмөр замын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлэх**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.6.2.1. Төмөр замын сүлжээг өргөтгөж, зорчигч тээрийн үйлчилгээг нэмэгдүүлэх;
- 4.6.2.2. Бусад аймгийн төвүүд болон хилийн боомт, уул уурхайн томоохон ордуудыг даган бий болох сууршлын төвүүдтэй холбосон хатуу хучилттай зам тавих;
- 4.6.2.3. Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлэн, хөгжүүлэх.

4.7.Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Зорилт-4.7.1: **Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг жилд дундажаар 30 хувиар өсгөнө.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 4.7.1.1: Төлөвлөгдөж буй 600 МкВт-ын цахилгаан станц баригдаж, эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдох хүртэлх хугацаанд айл өрхүүд, албан байгууллагуудын цахилгааны зохистой хэрэглээг тоолууржуулалтаар зохицуулж, суурингуудад үйлдвэрлэлийн зориулалттай шугамын зураг төслийг боловсруулан бэлтгэлийг хангах
- 4.7.1.2: Дулааны болон цахилгаан эрчим хүчний хэрэглээний үнийг үе шаттайгаар бууруулах төсөл тооцооллыг гаргаж бүс нутгийг үйлдвэрлэл үйлчилгээ, амьдрах орчны ая тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд бодлогын хувьд анхаарах, бичил бүсүүдийн шинэ сууршилийн бүсүүдэд дулааны эх

үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх асуудлыг судалж төсөл боловсруулан хэрэгжүүлэх;

4.7.1.3:Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, техникийн шинэчлэл хийх;

4.7.1.4:Аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд болон аймгийн төвөөс цахилгааны шугамаар холбогдсон сумдыг цагийн ялгаварт тоолуурт оруулж, цахилгаан эрчим хүчний өртөгийг бууруулах замаар хэрэглээг нэмэгдүүлэх;

4.7.1.5:Цахилгааны эх үүсвэрийг шинээр байгуулан, байнгын цахилгааны эх үүсвэргүй 3 сумыг холбох замаар аймгийн хэмжээнд эрчим хүчний нэгдсэн системд холбогдох;

4.7.1.6:УБ-Мандалговь - Оюутолгой-Тавантолгой чиглэлийн 220 В-ын өндөр хүчдэлийн шугамыг барьж байгуулах;

4.7.1.7:Тавантолгой - Даланзадгад чиглэлийн 110 В-ын өндөр хүчдэлийн шугамыг барьж байгуулах.

Зорилт-4.7.2:Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг сайжруулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.7.2.1.Сумдын түвшинд бага оврын халаалтын зуухтай хэрэглэгчдийг дулаан хангамжийн төвлөрсөн системд холбож, хэрэглээг нэмэгдүүлэх;

4.7.2.1.Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах;

4.7.2.1.Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллуулах;

4.7.2.4. Сумдын эрчим хүчний байгууллагын үйл ажиллагааг өргөтгөх, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургаж дадлагажуулах.

4.8.Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого

Зорилт-4.8.1:Шилэн кабелиар бичил бүсийн сумдыг тулгуур төвтэй, бичил бүсүүдийг аймгийн төвтэй холбох замаар мэдээлэл харилцааны шуурхай, найдвартай байдлыг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.8.1.1.“Цахим Монгол” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг үе шаттайгаар аймаг, сумдад бүрэн хэрэгжүүлэх;

4.8.1.2.Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулж үйлчлэх;

4.8.1.3.Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, энгийн хэрэглээ болгох;

4.8.1.4.Орон нутгийн телевизийг аймгийн нутаг дэвсгэрийг хамаран цацагдах боломжийг судлан үзэж холбогдох тооцооллуудыг хийн мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэх.

Зорилт-4.8.2:Сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбооны технологиор шинэчлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.8.2.1.Бүх сумдын иргэд, малчдад утасгүй холбоо, үүрэн телефоны үйлчилгээг хүргэх;

4.8.2.2. Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн шинэ төрлийн электрон үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлэх, Багийн шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх;

4.8.2.3. Аймгийн төвийн болон сумдын дамжуулах болон холбох байгууламжийг тоон технологид бүрэн шилжүүлэх.

Зорилт-4.8.3: Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүх байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ

4.8.3.1. Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн санг бүрдүүлэх;

4.8.3.2. Даланзадгад болон шинээр үүсэх суурингуудын эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбох.

Бүлэг V. Байгаль Орчны Тогтвортой Байдлын Бодлого

Бодлогын зорилго

Говь цөлийн бүсийн экологийн тэнцвэрийг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих.

5.1. Байгаль орчныг хамгаалах бүтэц/Институтчлалын стратегийн зорилтууд

Зорилт-5.1.1: Өмнөговь аймгийн байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчны тэнцвэрийг хадгалахад чиглэсэн шинэ бүтэц бий болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 5.1.1.1. Говийн бүсийн байгаль орчны зөвлөл байгуулах;
- 5.1.1.2. Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлийг байгуулах;
- 5.1.1.3. Усны нөөц, чанарын судалгаа, хяналтын нэгжийг байгуулах;
- 5.1.1.4. Байгаль орчны хяналт, шинжилгээний улсын лабораторийг байгуулах.

Зорилт-5.1.2: Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй технологийг нутагшуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 5.1.2.1. Байгальд ээлтэй технологийг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах;
- 5.1.2.2. Байгальд ээлтэй технологийг сурталчилан таниулах, мэдээллээр хангах, судалгаа шинжилгээ хийх зориулалт бүхий Технологи дамжуулалтын төв байгуулах;
- 5.1.2.3. Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг Өмнөговь аймгийн бизнес инкубатораар тусгайлан дэмжих;
- 5.1.2.4. Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулах таатай орчинг орон нутгийн түвшинд бүрдүүлэх.

Зорилт-5.1.3: Аймаг ба сумын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 40% хүргэж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 5.1.3.1. Улс, аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгаас уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал, хотхоны зориулалтаар газар чөлөөлөхгүй байх;
- 5.1.3.2. Аймгийн ба сумын тусгай хамгаалалттай газрыг шат дараалан өргөтгөх;
- 5.1.3.3. Улсын ба Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлэх;
- 5.1.3.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад олон улсын ба мэргэжлийн байгууллага, төрийн захиргааны төв байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- 5.1.3.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

Зорилт-5.1.4:Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.4.1.Хариуцлагатай уул уурхайн нэр бүхий найман зарчмыг Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлээр дамжуулан хэрэгжүүлэх;

5.1.4.2.Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлд уул уурхайн компаниуд хариуцлагатай уул уурхайн тайлангаа жил бүр хүргүүлдэг болгох;

5.1.4.3.Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, тээвэрлэлт үйл ажиллагаа эрхлэсэн аж ахуйн нэгжүүд байгаль орчны нөхөн сэргээж буй үйл явцад хяналт мониторингийг тогтмолжуулах;

5.1.4.4.Холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангуулах. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компани аж ахуйн нэгжүүдэд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг дахин хийх;

5.1.4.5.Жил бүр хариуцлагатай уул уурхайн чуулга уулзалтыг Даланзадгадад зохион байгуулах. Чуулганаар тогтвортой түншлэлийн тайланг авч хэлэлцэж уриалга, зөвлөмж гаргах;

5.1.4.6.Өмнөговь аймгийн хариуцлагатай уул уурхайн мэдээллийн санг байгуулах. Мэдээллийн агуулга, хүртээмжийг нэмэгдүүлэх. Иргэдэд зориулсан уулзалт, лекц, семинар зохион байгуулах;

5.1.4.7.Өмнөговь аймагт хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд мэргэжлийн байгууллага, ТББ, төрийн захиргааны төв байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

5.1.4.8.Түншлэлийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хангасан уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг нийгэмд алдаршуулах, сурталчилах ажлыг тогтмолжуулах.

Зорилт-5.1.5:Нутгийн иргэдэд суурилсан байгаль орчны хамгаалалтын механизмыг бүрдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1.5.1.Байгаль хамгаалж, байгалийн нөөцийг зохистой ашиглахад чиглэгдсэн малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагааг дэмжих;

5.1.5.2.Идэвхтэн байгаль хамгаалагч, нутгийн иргэдийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцож байгаагаар нь урамшуулдаг механизмыг бүрдүүлж, тусгай журмыг батлаж, мөрдөх.

5.2.Агаарын бохирдлыг бууруулах стратегийн зорилтууд

Зорилт-5.2.1:Бүсийн тулгуур төв хотуудад агаарын чанарыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2.1.1.Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд зэрэг сумдын төвд агаарын чанарын хяналтын харуул байгуулах;

5.2.1.2.Жил бүр агаарын бохирдлын асуудлаар бичил бүсийн төвүүдэд зөвлөгөөн хийх. Зөвлөгөөнөөр томоохон суурин, бичил бүсийн төвүүдийн агаарын бохирдлын байдал, цаашдын хандлага, хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцдэг байх;

5.2.1.3.Агаарын бохирдол бага үүсгэдэг бүх төрлийн технологийг хэрэглээнд нэвтрүүлэх, туршилт судалгааг тогтмол хийх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

5.2.1.4.Хотуудын ирээдүйн агаарын бохирдлын талаар таамаглалыг оновчтой дэвшүүлж, тулгарч болох эрсдэлүүдийг даван туулахад шаардлагатай арга хэмжээг урьдчилан авах;

5.2.1.5.Иргэд оршин суугчид, үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгжид агаарын бохирдлын талаар зөв мэдээлэл, мэдлэг олгох.

Зорилт-5.2.2:Томоохон суурин газрууд, Бичил бүсийн тулгуур төвүүдийн тоосжилтын түвшинг бууруулалахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2.2.1.Цагаан тоос дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх. Тус хөтөлбөрт Өмнөговь аймгийн томоохон суурин газрууд, бичил бүсийн төвүүдийг тоосжилтийн түвшинг шат дараалан бууруулах талаар тусгах;

5.2.2.2. Хот, суурин газрын хэтийн төлөвлөлтөнд тоосжилтыг бууруулах арга хэмжээг заавал тусгасан байх шаардлагыг тавьж ажиллах;

5.2.2.3.Хот орчмын газрын менежментд тоосжилт, түүнийг бууруулах талаар зорилтууд тусгаж, хэрэгжүүлэх.

Зорилт-5.2.3:Өмнөговь аймгийн карбон сан байгуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2.3.1.Агаарыг бохирдуулагч нөхөн төлбөр төлдөг байх зарчимд тулгуурлан үйл ажиллагаа явуулах Өмнөговь аймгийн карбон сангийн журмыг ИТХ-аар батлуулах;

5.2.3.2.Карбон сангийн үйл ажиллагааг иргэд, оршин суугчдад ил тод байлгах, жил бүр сангийн хуримтлал, зарцуулалтын талаарх тайлан гаргаж нийтэд мэдээллэх;

5.2.3.3.Сангийн үйл ажиллагаа, иргэд оршин суугчдад өгч буй өгөөж, эерэг үр нөлөөний талаар байгууллага, иргэдэд сурталчилан таниулах үйл ажиллагаа зохиох.

5.3. Усны нөөцийг зохистой ашиглах стратегийн зорилтууд

Зорилт-5.3.1:Усны асуудал эрхлэсэн нэгжээр дамжуулан гадрагын болон гүний усны нөөц, ашиглалт, бохирдолтонд хяналт, мониторинг хийх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.3.1.1.Усны асуудал эрхлэсэн нэгж нь Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлд жил бүр Өмнөговь аймгийн гадаргын ба гүний усны тайлангаа хүргүүлдэг байх;

5.3.1.2.Усны асуудал эрхлэсэн нэгж Өмнөговь аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд, байгууллага аж ахуйн нэгж, иргэдтэй нягт хамтран ажиллах;

5.3.1.3.Төвийн бүсийн тулгуур төв хотод усны чанарын хяналтын лабораторийг Усны нэгжийн харьяанд байгуулах;

5.3.1.4.Усны хайгуул судалгааг аймгийн хэмжээнд хийж, уст цэгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох.

Зорилт-5.3.2:Усны ашиглалтын бодлогыг нээлттэй зах зээлд зарчимд нийцүүлэн шинэчилэх, ирээдүйд үүсч болох сөрөг үр дагварыг урьдчилан харж, тэдгээрийг даван туулахад чиглэсэн хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.3.2.1.Усны үнийг чөлөөлөх;

5.3.2.2.Гүний усыг бохирдлоос хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5.3.2.3.Уул уурхайн үйлдвэрлэл, бусад үйлдвэрийн газруудад хэрэглэж буй усаа дахин ашигладаг технологийг нэвтрүүлэхийг бодлогоор урамшуулах.

Зорилт-5.3.3:Иргэд, оршин суугчдын ундны усны чанарыг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.3.3.1.Өмнөговь аймгийн Ус дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийж, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчилэн төлөвлөж хэрэгжүүлэх;

5.3.3.2.Бичил бүсийн тулгуур төв хот, томоохон суурин газруудад ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах;

5.3.3.3.Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинээр худаг гаргах, хуучин худгуудыг сэргээн засварлах, хиймэл далан, хөвөө барих ажлуудыг жил бүрээр төлөвлөн хэрэгжүүлэх.

5.4.Хөрс түүний бүрхэгч, ургамалын нөмрөг хамгаалах, нөхөн сэргээх стратегийн зорилтууд

Зорилт-5.4.1:Ашигт малтмалын хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэх үед бий болдог хөрсний бохирдлын хэмжээг багасгах, нөхөн сэргээлт хийх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.4.1.1.Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниуд Байгаль орчны хамгаалан тэтгэх түншлэлд тухайн оны хөрс хуулалт ба нөхөн сэргээлтийн тайлангаа жил бүр хүргүүлдэг болгох;

5.4.1.2.Түншлэлээс хөрсний бохирдол үүсгэх эрсдэлт газруудыг судлан тогтоож, мэдээллийн санг бий болгох;

5.4.1.3.Хөрсний бохирдлыг саармагжуулах ажлыг тогтмолжуулах ажлыг бодлогоор дэмжих;

5.4.1.4. Нөхөн сэргээлтийг хуваарын дагуу хийсэн, хөрсний эвдрэл, талхлалтыг бууруулсан аж ахуйн нэгж, иргэдийг дэмжин урамшуулж, нийтэд сурталчилах

Зорилт-5.4.2:Түлшний дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх

5.4.2.1.Түлшний дэд хөтөлбөрийг Өмнөговь аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулах;

5.4.2.2.Нутгийн иргэд, малчдын ердийн хэрэглээний заг, сухай, харгана зэрэг олон нас ургамалыг орлохуйц түлшний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих хөгжүүлэх;

5.4.2.3.Иргэд, малчдыг говийн олон наст ургамалыг ердийн хэрэгцээнд ашиглахгүй байхад чиглэсэн компанит ажил өрнүүлэх.

Зорилт-5.4.3:Ургамалын нөмрөгийн хамгаалалтыг байгалийн бүслүүр, тусгай хамгаалалттай газрын хил, бэлчээрийн газрын ангилалтай уялдуулан хамгаалах бодлого баримтлах

5.4.3.1.Бэлчээр, отор, хот суурин орчмын бэлчээрийн дэглэм ба удирдлагыг боловсронгуй болгох;

5.4.3.2.Говь гурван сайхан уулын ландшафтын зүйлийн хамгаалах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

5.4.3.3.Эмийн болон ашигт ургамалын зохистой ашиглах, нөхөн сэргээх аймгийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

5.5.Хог хаягдал оновчтой удирдлага бий болгох стратегийн зорилтууд

Зорилт-5.5.1:Өмнөговь аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдмэл удирдлагын механизм бий болгож, байгаль орчны бохирдол, хүрээлэн буй орчны доройтлыг арилгах

5.5.1.1. Аймгийн ба сумын төвүүдийн хогийн цэгийг тэмдэгжүүлэх, хязгаарлалтын гортиг, хогийг ангилан ялгах механизм бий болгох, хогийн хуучин цэгүүдийг хөрсөөр хучих;

5.5.1.2.Цацраг идэвхит болон химийн хорт бодисын хор уршгийг бууруулахад чиглэсэн дунд хугацааны төлөвлөгөөг гурван бүсийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх;

5.5.1.3.Иргэдийн гар аргаар алт олборлосон газруудыг нөхөн сэргээх, хөрсний эвдрэл, бохирдлыг арилгахад хандивлагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах;

5.5.1.4.Бүсийн тулгуур төвүүдэд байгальд удаан задардаг, хатуу хог хаягдлыг дахин боловсруулах цехүүдийг байгуулах.

5.6.Ойжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратегийн зорилтууд

Зорилт-5.6.1:Өмнөговь аймгийн гурван бүсийн хэмжээнд ногоон хэрэм дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх

5.6.1.1.Ногоон хэрэм аймгийн дэд хөтөлбөрийг талуудын оролцооны зарчимд тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй байгуулах;

5.6.1.2.Ногоон хэрмийг задгай булаг шанд, баян бүрд, горхи, гадаргад ойрхон уст цэгүүдийг дайруулан байгуулах;

5.6.1.3.Заган ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

5.6.1.4.Ногоон хэрэм хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, бичил бүсүүд, сумдын хэмжээнд хангаж ажиллах.

Зорилт-5.6.2:Даланзадгад суманд говь цөлийн олон наст ургамалуудыг судлах, тарьмалжуулах Говийн бүсийн ботаникийн хүрээлэн байгуулах

5.6.2.1.Говийн бүсийн ботаникийн хүрээлэнг байгуулах асуудлаар Төрийн захиргааны төв байгууллагатай идэвхитэй хамтран ажиллаж шийдвэрлэх;

5.6.2.2.Говийн бүсийн ботаникийн хүрээлэнг ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн харьяанд байгуулж мэргэжлийн боловсон хүчнээр хангах;

5.6.2.3.Говийн бүсийн ботаникийн хүрээлэнгийн үйл ажиллагааг олон улсын мэргэжлийн байгууллагуудтай нягт уялдуулах, мэргэжилтэн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

Зорилт-5.6.3:Бүсийн тулгуур төв болон сумдын төвүүдийг ойн зурвастай болгох, иргэд, ТББ, хоршоодын мод тарих үйл ажиллагааг бодлогоор дэмжих

5.6.3.1.Одоогийн мөрдөгдөж буй журмыг илүү боловсронгуй болгон дунд хугацаанд мөрдөж, урамшуулалын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, мод тарьсан иргэдэд олгох;

5.6.3.2.Мод тарих иргэдийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дадлагажих сургалтуудыг тогтмол зохион байгуулах.

5.7.Биологийн олон янз байдлыг хамгаалах стратегийн зорилтууд

5.7.1.Уул уурхайн сөрөг нөлөөллөөс биологийн олон янз байдлыг хамгаалах журам боловсруулж мөрдүүлэх;

5.7.2.Биологийн олон янз байдлын нөөц, түүнд үзүүлж буй одоогийн болон ирээдүйн дарамтуудыг судлан тогтоох;

5.7.3.Биологийн олон янз байдалд нөлөө үзүүлэх хүн амын хөдөлгөөн, нутагшил суурьшил болон уул уурхайн үйлдвэрлэлийн үнэлгээ, хяналтын тогтолцоог бий болгох;

5.7.4.Биологийн олон янз байдлыг хамгаалах олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх;

5.7.5.Биологийн олон янз байдал, түүнийг хамгаалахад нутгийн иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх;

5.7.6.Цахилгааны дамжуулах агаарын шугамыг барьж байгуулах нүүдлийн болон суурин шувуудын амьдрах, нүүдэллэх орчинд нийцсэн байхаар шийдэл боловсруулж, хэрэгжүүлэх;

5.7.7.Автозам, төмөр замын дэд бүтцийг барьж байгуулахад хулан, хар сүүлт, цагаан зээр гэх мэт зэрлэг амьтадын нүүдэллэх боломжийг хангасан байхаар газар гүүр, түнэл барих журам гаргаж мөрдүүлэх;

5.7.8.Говийн бүсийн экосистемд нөлөө үзүүлэх шүхэр зүйлийг тодорхойлж, хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.

5.8.Гамшигаас урьдчилан сэргийлэх стратегийн зорилтууд

5.8.1.Ган зудны эрсдэлийг даван туулах зорилгоор мал аж ахуй, газар тариалангийн өнөөдрийн бүтэцэд шаардлагатай өөрчлөлт оруулах;

5.8.2.Усалгаатай газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг бодлогоор дэмжин хөгжүүлэх;

5.8.3.Шороон шуурга, элсний нүүдэл, үер усны аюул, ган, зуд зэрэг гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, муу үр дагаварыг багасгахын тулд Эрсдэлийн сан, Байгаль хамгаалах сангийн санхүүжилтийн нэмэгдүүлэх.

5.9.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийн зорилтууд

5.9.1.Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, цөлжилт, шар шороон шуурга зэргийн нөлөөнд хамгийн их өртдөг бүс нутгийн хувьд эдгээр асуудлаар Ази номхон далай бүс нутаг, цаашлаад дэлхийн хэмжээний олон талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох;

5.9.2.Монголын говь цөлийн экосистемийн уур амьсгалын өөрчлөлт, түүний цаашдын төлөв, үр нөлөөг судлах олон улсын судалгааны байгууллагын санаачилах;

5.9.3.Уур амьсгалын өөрчлөлтийн аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулах;

5.9.4.Автомат станцийн үйл ажиллагааг өргөтгөх, тоог нэмэгдүүлэх;

5.9.5.Уур амьсгалын лавлахыг шинэчилэн боловсруулах.

5.10.Цөлжилттэй тэмцэх стратегийн зорилтууд

5.10.1.Цөлжилтийг бууруулах аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ;

5.10.2.Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг Өмнөговь аймгийн төсөв болон Хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр санхүүжүүлэх;

5.10.3.Цөлжсөн газарт нутгийн унаган мод, сөөгний сэргэн ургалтыг тэтгэх, шинээр мод, бут тарина;

5.10.4.Усны менежментийн боловсронгуй болгож цас, борооны усыг тогтоох барилга байгууламж барьж, зарим газар усжуулах системийг ашиглана;

5.10.5.Авто замыг журамлаж хөрсний эвдрэлээс хамгаалах, орон нутгийн замуудыг тэмдэгжүүлэх, чиглэл тус бүр заагдсан замаар зорьчдог болгох;

5.10.6.Цөлжилттэй тэмцэхэд нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. Цөлжилттэй тэмжих ажилд оролцох иргэдийн оролцоог эдийн засгийн хөшүүрэг хэрэглэдэг болгоно;

5.10.7.Загны хэрэглээг зогсоож, орлох түлшний үйлдвэрлэлийг байгуулж, хэрэглээг эрчимжүүлнэ;

5.10.8.Усны эхүүд, баянбүрдүүдийг хамгаалах, хашаа хайс барих ажлын шат дараалан гүйцэтгэнэ.

5.11.Экологийн боловсрол олгох стратегийн зорилтууд

5.11.1.Байгаль хамгаалах сайн дурын клуб, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ;

5.11.2.Аймгийн бүх ЕБС-уудад экологийн танхимуудыг нээн ажиллуулна;

5.11.3.Говийн бүсийн байгаль хамгаалал, иргэдийн оролцооны талаар жил бүр улсын чанартай хурал, чуулганыг зохион байгуулна;

5.11.4.Говь цөлийн экосистем, түүний онцлог, биологийн олон янз байдал, экологийн тэнцвэрийг хадгалахын ач холбогдол, экосистемд үзүүлж буй хүний буруутай үйлдэл, дэлхийн байгаль орчинд тулгамдаж буй асуудлууд зэрэг сэдвийн хүрээнд сурагчид, залуучууд, нутгийн иргэд, шилжин ирэгсэдийн ойлголтыг нэгтгэх, мэдлэгийг нэмэгдүүлэх.

5.12.Хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн зорилтууд

5.12.1.Говийн бүсийн байгаль орчны зөвлөлийг бүсийн аймгууд, олон улсын байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран байгуулах;

5.12.2.Говийн бүсийн биологийн олон янз байдлыг хамгаалах стратеги төлөвлөгөөг бүсийн аймгууд, олон улсын байгууллага, уул уурхайн компаниуд, иргэдийн оролцоотойгоор боловсруулах;

5.12.3.Цөлжилт, шар шороон шуурга, элсний нүүдэл, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудлаар улсын ба олон улсын чанартай хурал, чуулганыг тогтмол зохион байгуулах. Даланзадгайн тунхаглал, уриалга, протокол зэргийг гаргах;

5.12.4.Тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийн төлөвлөгөөг бүх талуудын оролцоотойгоор боловсруулж, нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх.

Бүлэг VI. Хотын Хөгжлийн Бодлого

Бодлогын зорилго

Хот байгуулалтын зорилго нь бичил бүсийн тулгуур хотуудын хөгжлийг түргэтгэх, хүрээлэн буй орчинд ээлтэй, хүний амьдрах тааламжтай орчныг бий болгосон орчин үеийн хот байгуулах явдал юм.

6.1.Хот төлөвлөлт, бүтээн байгуулалтын стратегийн зорилтууд

Зорилт-6.1.1:Газар ашиглалтыг сайжруулан, хот төлөвлөлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1.1.1.Аймгийн холбогдогдох бодлогын бичиг баримтууд болон уул уурхайн ашиглалт, экосистемийн өнөөгийн нөхцөл, цаашдын хандлага, бэлчээр ашиглалт, хүн амын суурьшилтай уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;

6.1.1.2.Хотын ерөнхий төлөвлөгөөг тулгуур төвүүдэд 2011 онд, бусад суурин газрын ерөнхий төлөвлөгөөг 2012 багтаан дахин нягтлан авч үзэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах, шинэчлэн боловсруулсан төлөвлөгөөг батлах;

6.1.1.3.Бүсийн сумдын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, бүсийн тулгуур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцдаа тодотголыг оновчтой хийж, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.1.4.Тулгуур төвүүдийн кадастрын зураглалыг сайжруулах, газар өмчлөлийн бүртгэлийг сайжруулан үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд хамруулах;

6.1.1.5. Хотын оршин суугчдыг үерийн усны аюулаас хамгаалах зорилгоор үерийн даланг барьж байгуулах;

6.1.1.6.Үерийн далан байгуулж, Инженерийн бэлтгэл ажлыг хийх. Үүнд газрын гадаргууд тэгшилгээ хийх, үер, хөрсний хуралт, элсний нүүлт, цасны хунгарлалтаас хамгаалах бэхэлгээ хийх, далан суваг, гүүр, гарц, зам талбай барьж байгуулах урьдчилсэн арга хэмжээ авах ажлыг хамруулан ойлгоно. 2012-2013;

6.1.1.7.Хот орчмын түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийг тогтоох, түүнийг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад хувийн хэвшлийн оролцоог чиглүүлэх;

6.1.1.8.Хот орчмын газар нутагт бэлчээрийн болон оршуулгын тусгай хэрэгцээний газрын хуваарилалт хэтийн бодлоготой уялдуулан хийх;

6.1.1.9.Бүсийн тулгуур төв болон сумдад үндэсний зан заншил, соёлыг хүндэтгэн санал асуулгын үндсэн дээр тодорхой газар заан чимээгүй хот байгуулах;

6.1.1.10.Заагдсан газраас бусад газарт оршуулах ёс гүйцэтгэхгүй байхыг олон нийтэд мэдээлж, ойлгуулах.

Зорилт-6.1.2:Хотын байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар доорхи инженерийн байгууламж, автозамыг барих ажлыг эхний ээлжинд хэрэгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1.2.1.Тулгуур төвүүдэд газар доорхи инженерийн байгууламжийг иж бүрнээр барьж байгуулах;

6.1.2.2.Хот төлөвлөлтийн төлөвлөгөөний дагуу газар доорхи инженерийн байгууламжийг барьж байгуулах чиглэлээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

6.1.2.3. Хотын оршин суугчдын ахуйн болон ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, цэвэрлэх байгууламжийг шинэ технологийг нэвтрүүлж, барьж байгуулах;

6.1.2.4. Хотын төв доторхи автозамыг шинээр барих болон засвар шинэчлэлтийг хийж, хотын төв доторхи тоосжилтыг багасгах.

6.2. Амьдрах орчныг сайжруулах стратеги

Зорилт-6.2.1: Хотыг орон сууцжуулах замаар хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулж, хангамжийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.2.1.1. Төвөлөгөөний дагуу орон сууцны зориулалтаар тусгагдсан газруудад дэд бүтцийг байгуулах, орон сууц барих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэх;

6.2.1.2. Орон нутагт барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, барилгын ханын материалын үйлдвэрлэлийг түлхүү дэмжих;

6.2.1.3. 2015 онд аймгийн хэмжээнд хүн амын 30%-ийг орон сууцаар хангана. 2021 онд Аймгийн эхмжээнд хүн амын 60%-ийг орон сууцаар хангана;

6.2.1.4. Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбож, нөхцлийг сайжруулах;

6.2.1.5. Хот төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг хот төлөвлөлтөд тусгах;

Зорилт-6.2.2: Гэр хорооллыг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.2.2.1. Гэр хорооллын байнгын суурьших хэсгээс түр суурьшлыг ялгаж, барилгажих цаг хугацааг оновтой төлөвлөн, барилгажилтын бүсэд шилжүүлэх ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу зохион байгуулах /Тулгуур хотын гэр хорооллыг түр суурьшилтын бүс буюу барилгажих талбай, урт хугацааны суурьшилтын гэсэн хоёр дэд хэсэгт авч үзнэ. Түр суурьшилтын бүсэд үндсэн хийц нь капиталын барилга бариулахгүй бөгөөд нэгдсэн хашаатай байна. Энэ нь бүтээн байгуулалтын ажил өрнөх хугацаанд түр суурьших, эхний ээлжинд орон сууцанд байх айлуудад зориулагдана;

6.2.2.2. Гэр хорооллын төлөвлөлтийг иргэдийн оролцоо, санаачлагын дагуу боловсрогуй болгох ажлыг зохион байуулах;

6.2.2.3. Гэр хорооллыг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож, амины оронсууцуудын нөхцлийг сайжруулах;

6.2.2.4. Гэр хороололд агаар ус хөрсийг бага бохирдуулах халаалтын зуухыг бүрэн нэвтрүүлэх;

6.2.2.5. Ерөнхий төлөвлөгөөний дагуу зураг төслөөр баригдсан орон сууцны хороолол болон урьдчилан төлөвлөлтгүйгээр баригдсан гэр хорооллын хоорондын ялгааг багасгаж, орчин үеийн амины орон сууцны хотхон болгож хөгжүүлэх бодлого баримтлах;

6.2.2.6. Урт хугацаанд гэр хороололыг сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

6.3. Тогтвортой хөгжлийн стратеги

Зорилт-6.3.1: Нийтийн аж ахуйг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.3.1.1.Цэвэр ус, дулааны үнийг тэдгээрийг түгээх, үйлдвэрлэн гаргахад гарах зардлыг санхүүжүүлж чадахуйц байлгахын тулд суурь үнийг чөлөөлөх;

6.3.1.2. Нийтийн аж ахуйн газрыг хувийн хэвшилд шилжүүлж, эдийн засгийн үр ашигтай, бие даасан өөрийгөө санхүүжүүлэх, ашгийн байгууллага болгох замаар тулгуур төвүүдэд болон бүсийн сумдад салбарыг байгуулан өргөжүүлэх.

Зорилт-6.3.2: Хотын ногоон байгууламжийг бий болгож, хот орчмын эко системийг хамгаалах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.3.2.1.Хотын ногоон байгууламжийг өргөтгөж, ойн зурвасуудыг байгуулах;

6.3.2.2.Бүсийн тулгуур төв болон бүсийн сумдад ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллах;

6.3.2.3.Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн байгуулагыг ажиллуулах;

6.3.2.4.Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн услалтын системийг шинэчлэн засварлаж, өргөтгөн ашиглалт хамгаалалтыг сайжруулах.

Зорилт-6.3.3: Хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.3.3.1. Бүсийн сумдад хог хаягдлыг боловсруулах, устгах үйл ажиллагааг явуулах аж ахуй нэгжийг бодлогоор дэмжих;

6.3.3.2.Хотын доторхи ил задгай хог хаягдыг бий болгосон аж ахуй нэгжид авах арга хэмжээг боловсруулан, мөрдөж хариуцлагыг тооцож ажиллах;

6.3.3.3. Хог хаягдлын хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг сурталчилах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх;

6.3.3.4.Бүсийн тулгуур төвүүдийн тохижилт үйлчилгээний компаниудад хог хаягдлыг дахин боловсруулахад дэмжлэг үзүүлэх. Хоёрдогч түүхий ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зах зээлийг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.3.3.5.Хот суурин газарт байрлах үйлдвэр, уурхай, аж ахуйн нэгж байгууллагуудын гаргаж байгаа хог хаягдалд үнэлгээ өгч шаардлагатай тохиолдолд ахуйн хаягдлаас ялгаатай үнэ тогтоох.

Бүлэг VII. Өмнөговь Аймгийн Хөгжлийн Хөтөлбөрийн Бүтэц Зохион Байгуулалт

Бүсчилсэн хөгжлийн бүтэц зохион байгуулалт нь орон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагуудаас бүрдэж байгаа төдийгүй иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг өөртөө багтаасан ойлголт юм. Иймээс одоогийн байгаа бүхий л бүтцүүдээс хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан бүс нутгийг хөгжүүлэх стратегиудад нийцүүлэн зохион байгуулах шаардлагатай юм. Хөгжлийн хөтөлбөр нь зорилтод тулгуурласан үзэл баримтлал учраас тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд одоогийн байгаа болон шаардлагатай нэмэлт бүтцийг бий болгосноор үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалтыг авч үзэхдээ одоогийн Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар, түүний хэлтэс, нэгжүүд, зарим хувийн хэвшлийн болон бусад байгууллагуудыг авч үзлээ.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын үүднээс бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн цөм нь бүсийн зөвлөл байна. Өмнөговь аймгийн бичил бүсүүдийн удирдлага бичил бүсийн зөвлөл байхаар томъёологдож байна.

Бичил бүсийн зөвлөлийг тухайн бүсийн орон нутгийн удирдлага ИТХ, Засаг даргын тамгын газрын төлөөллийг оролцуулан байгуулна.

Бичил бүсийн зөвлөлүүд нь засаг захиргааны нэгж биш бөгөөд бүс нутгийн хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүсийн нийгэм эдийн засгийн асуудлуудыг зохицуулах чиг үүрэгтэй байна.

Өмнөговь аймгийн ЗДТГ, болон бичил бүсийн тулгуур төвүүдийн ЗДТГ нь хөгжлийн бодлогын хэрэгжилтийг удирдан явуулна. Харин бичил бүсийн зөвлөлүүд нь бичил бүсийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах үүрэг хүлээнэ.

7.1. Эрх мэдэл, үүрэг хариуцлага

Бичил бүсийн зөвлөл

- Бичил бүсийн зөвлөл нь хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны хөтөлбөрт тусгуулах арга хэмжээг авах үүрэгтэй.
- Бичил бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах, өөрчлөлт оруулах, түүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

ИТХ

- Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хөгжлийн байдал, хэтийн төлвийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
- Бүсийн хөгжлийн асуудлаар Засаг даргын тайланг хэлэлцэх
- Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагуудын оролцоог дэмжин ажиллах
- Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, мониторинг хийх

Засаг даргын тамгын газар

- Бүс нутгийн хөгжлийн асуудлаар гарсан бүсийн зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх
- Бүсийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Бичил бүсийн хөгжлийн талаар хийж байгаа ажлуудыг бүсийн зөвлөлд танилцуулах

Мөн одоогийн бүтэц зохион байгуулалтад байхгүй боловч хөтөлбөр хэрэгжүүлэх явцад шаардлагатай зарим байгууллага шаардлагатай байгаа тул дараах санаачлагуудыг хөтөлбөрт оруулж байна.

Шинээр санаачлан оруулж байгаа байгууллага /бүтэц/ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд болон цаашид гарах хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

- Өмнөговь Хөгжлийн Сан;
- Усны Асуудал Эрхэлсэн Газар;
- Нийгмийн Хариуцлагын Түншлэл;
- Байгаль Орчныг Хамгаалан Тэтгэх Түншлэл.

7.2.Өмнөговь Хөгжлийн Сан

Үндэслэл: Орон нутагт дэд бүтэц болон бусад салбарт төсвийн хөрөнгө хүрэлцдэггүй, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх урт хугацааны хөрөнгө оруулалтуудад зориулсан санхүүжилтийн эх үүсвэрүүд хомс гэх мэт.

Зорилго: Уул уурхайн хөгжилд тулгуурлан Өмнөговь аймгийн эдийн засгийн ирээдүйн өсөлтийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа:

- Орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих төслүүдийг санхүүжүүлэх банк болон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан орон нутагт хөрөнгө оруулах
- Хөрөнгийн менежмент хийн, сангийн хөрөнгийн тогтвортой өсөлтийг хангах

7.3.Усны Асуудал Эрхэлсэн Газар

Үндэслэл: Уул уурхайн компаниуд болон хотын хэрэгцээнд их хэмжээний гүний усны нөөцийг зохистой ашиглахгүй бол усны хомсдолд орох бодит эрсдэл бий.

Зорилго: Шинээр судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих замаар Өмнөговь аймгийн усны нөөцийн тогтвортой байдлыг хангах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх

Үйл ажиллагаа

Бодлого зохицуулалт:

- Салбарын яамд, мэргэжлийн агентлаг, судалгаа шинжилгээний байгууллагуудаас гаргасан бодлогыг нэгтгэн зангидаж зохицуулах,
- Худгуудын өмчлөлийн асуудлыг хариуцан ажиллах
- Усны үнийн тарифийн зохицуулалтын бодлогыг аймагт хэрэгжүүлэх
- Орон нутаг дахь инженерийн шугам сүлжээний ашиглалтыг хариуцах

Судалгаа:

- Шинээр өрөмдлөг болон шаардлагатай судалгаа шинжилгээг хийх,
- Гүний усны хэрэглээнээс хамааран экосистемд үүсэх нөлөөг тогтоох
- Ундны усны чанарын төвшинг тогтоох

Хэрэгжүүлэлт:

- Хуучин худгуудыг засаж сэргээх, ашиглатанд оруулах ажлыг удирдан хариуцах,
- Уул уурхайн компаний байгаль орчинд нөлөөлөх байдалд хяналт тавих
- Инженерийн шугам сүлжээний төлбөр тооцоог хариуцдаг, цэвэр бохир усны асуудлыг зохицуулдаг

7.4.Нийгмийн Хариуцлагын Түншлэл

Үндэслэл: Уул уурхайн компаниуд тус тусдаа нийгэмд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд үйл ажиллагаанууд давхардаж, боломжит хэмжээнд хүртэл өгөөж өгөхгүй байх магадлалтай

Зорилго: Нийгмийн хөгжилд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг чанартай, үр өгөөж өндөртэй байхад зориулан зохицуулан удирдах

Үйл ажиллагаа:

- Уул уурхайн компаниуд, орон нутгийн удирдлага, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан нийгмийн хариуцлагын түншлэл нь эдгээр оролцогчдийн нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг зангидах
- Нийгэмд чиглэгдэн хийгдэх үйл ажиллагаануудыг ач холбогдлоор нь ангилж, дэс дараатай, тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх
- Шаардлагатай үйл ажиллагааг хэлэлцэн санаачилж, өргөн хүрээн авч хэрэгжүүлэх

7.5.Байгаль Орчныг Хамгаалан Тэтгэх Түншлэл

Үндэслэл: Уул уурхайн ашиглалт, дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт өндөр түвшинд явагдаж эхлэх үед байгальд учруулах хүний нөлөө нэмэгдсэнээр сөрөг нөлөө үүсэх эрсдэл өндөр

Зорилго: Байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах

Үйл ажиллагаа:

- Бүс нутгийн ургамал, амьтны аймгийн төрөл зүйлүүдэд учирч буй нөлөөг хянаж, эдгээр үүсч буй/болох сөрөг нөлөөг тодорхойлох
- Хүний оролцоотой үйл ажиллагаанаас гарах нөлөөллийг сэрэмжлэх үүднээс санал санаачлага боловсруулан зохих газруудад хүргүүлэн, үр дүнг хянах
- Судалгаанд тулгуурлан байгальд ээлтэй арга замыг нэвтрүүлэхэд байгууллагуудад туслах
- Байгальд шууд сөрөг нөлөө үзүүлж буй асуудлуудад өөрийн эрх зүйн хүрээнд интервенци хийж, хориг тавих